



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2025 – 11 САР | ДУГААР 84

ГАРЧИГ

- 1–3** Бодлогын нийтлэл
- 4–5** Зохицуулалтын мэдээ
- 6–7** Ярилцлага
- 8–9** Тогтвортой санхүүжилт
- 10–11** Компанийн засаглал, комплайнс
- 12–14** Финтек ба регтек
- 15–23** Судлаачийн индэр
- 24–25** Мөнгө хүүлэлт гэж юу вэ?
- 26–27** Олон улсын зах зээлийн мэдээ
- 28** Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсад даатгалын зуучлал нь даатгалын салбарын өрсөлдөөн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн сонголтыг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 62 компани (үүнээс, 9 банк-даатгалын зуучлагч, 11 давхар даатгалын зуучлагч) үйл ажиллагаа эрхэлж байгаагаас гадна даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 1,000 гаруй хувь хүн даатгагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээ, хэлцэл хийх үйл ажиллагааг явуулж байна.

Зарим тоон мэдээлэлд үндэслэн даатгалын зуучлалын салбарын ерөнхий байдлыг тодорхойлбол, энэ оны хагас жилийн байдлаар даатгалын нийт хураамжийн орлогын 24.6 хувийг даатгалын зуучлагч компаниуд бүрдүүлсэн байгаа бөгөөд даатгалын зуучлагчаар дамжуулан бүрдүүлсэн хураамжийн орлогын 46.2 хувийг даатгалын зуучлагч банкнууд, 32.4 хувийг давхар даатгалын зуучлагчид бүрдүүлсэн үзүүлэлттэй байна. Гэтэл даатгалын зуучлалын зах зээлийн 78.6 хувийг зөвхөн 20 даатгалын зуучлагч компани бүрдүүлсэн байгаа нь цаашид даатгалын зуучлалын зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байгаа юм. Түүнчлэн, даатгалын зуучлагчдын борлуулалтын 35.5 хувийг автотээврийн хэрэгслийн даатгал, 31.8 хувийг хөрөнгийн даатгал эзэлж байгаа бол зээлийн даатгалын хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүний борлуулалтыг зөвхөн даатгалын зуучлагч банкнууд хийсэн байна. Энэ нь даатгалын зуучлагчдын чадавх болон бүтээгдэхүүн борлуулалтыг төрөлжүүлэх шаардлагатайг илтгэж байна.

Даатгалын зуучлагч нь даатгагч болон даатгуулагчийн хооронд зуучлан ажиллаж, хэрэглэгчдэд даатгалын бүтээгдэхүүнийг ойлгомжтой байдлаар хүргэх, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн зөвлөгөө өгөх, гэрээ байгуулах, нөхөн төлбөрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг гүйцэтгэдэг даатгалын салбарын гол оролцогчдын нэг юм.

Гэвч өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэвэл салбарын хөгжилд дараах гол асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Зуучлагчдын мэргэжлийн чадавх, ёс зүйн стандартын ялгаа;
- Зах зээлд эзлэх хувь харьцангуй бага (нийт хураамжийн орлогын 25–35%–ийг бүрдүүлж байна);
- Цахим даатгал, технологийн шилжилтийн эрчим сул;
- Хэрэглэгчийн итгэлцэл, мэдээллийн хүртээмж хязгаарлагдмал байгаа зэрэг асуудлууд юм.



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

Зуучлалын гэрээ

Brokerage Agreement/

Зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, зуучлуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол хөлс, шагнал төлөхөөр харилцан тохиролцсон хэлцэл. Хөлс, шагналын хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ. Хугацааг харилцан тохиролцоогүй бол зуучлалын гэрээг хэдийд ч дуусгавар болгож болно. Холбогдох хууль – Иргэний хууль.



Зээлийн гэрээ

Loan agreement

Зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээсэн хэлцэл. Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулсанд тооцно. Холбогдох хууль – Иргэний хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь 2024 он

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Эхлэл нь 1-р нүүрт

Эдгээр нөхцөл нь даатгалын салбарын хөгжлийн түвшин, эдийн засгийн бүтцээс хамааралтай төдийгүй, зохицуулалтын орчны шинэчлэл, дижитал шилжилттэй нягт уялдаж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн даатгалын салбарт бизнесийн бүтцийн хувьд ихээхэн өөрчлөлт өрнөж байна. Даатгалын компаниуд “бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба борлуулах” уламжлалт загвараас аажмаар татгалзаж, даатгалын зуучлагч болон гуравдагч этгээдийн (third-party service providers) тусламжтайгаар борлуулалт, үйлчилгээ, нөхөн төлбөрийн үйл ажиллагаагаа гүйцэтгүүлж, компанийн гол үйл ажиллагаа болох эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд голчлон төвлөрөх хандлага хүчтэй ажиглагдаж байна. Энэхүү хандлага нь даатгалын салбарын бүтээмж, үр ашиг, технологийн хурд, хэрэглэгчийн хандлагын өөрчлөлттэй шууд холбоотой. Тухайлбал Европын холбооны улсуудын даатгалын хураамжийн орлогын 80 гаруй хувийг даатгалын зуучлагч нар бүрдүүлж байгаа бол Монгол Улсын хувьд даатгалын хураамжийн орлогын 25 гаруй хувийг даатгалын зуучлагч нар бүрдүүлж байна.

Олон улсад даатгалын компаниуд дараах зургаан гол чиглэлд бүтээгдэхүүн борлуулалтын стратегиа төвлөрүүлж байна:

Хэрэглэгч төвтэй бүтээгдэхүүн ба хувь хүнд тохирсон санал (Personalized Insurance)

- Хэрэглэгчийн өгөгдөлд тулгуурлан амьдралын мөчлөгт тохирсон бүтээгдэхүүн гаргах.
- “Dynamic pricing” буюу эрсдэлийн өгөгдлөөр бодит цагийн тариф тогтоох.

Цахим борлуулалт ба InsurTech-ийн интеграцчилал

- Онлайн даатгалын платформ, гар утасны аппликэйшнээр дамжуулан борлуулах.
- “Embedded insurance” буюу банк, цахим худалдаа, аяллын үйлчилгээний платформд даатгал автоматаар суулгах.

AI ба дата-д суурилсан автомат борлуулалт

- Чатбот, хиймэл оюун ухаан ашиглан бүтээгдэхүүн санал болгох.
- Дата анализ ашиглан хэрэглэгчийн зан төлөвийг урьдчилан таамаглах.

Omni-channel буюу олон сувгийн борлуулалтын стратеги

- Хүний итгэлцэл ба дижитал шийдлийг хослуулах.

- Агент, зуучлагчийг CRM болон онлайн платформоор холбох.

Ногоон болон нийгмийн хариуцлагатай даатгалын бүтээгдэхүүн

- ESG болон уур амьсгалын эрсдэлийн даатгал.
- Орлого багатай бүлэгт чиглэсэн бичил даатгалын бүтээгдэхүүн.

Хамтын ажиллагаа ба экосистемийн интеграцилал

- Fintech, банк, цахим худалдааны платформуудтай хамтран бүтээгдэхүүн борлуулах.
- API, дата холболтоор даатгалын бүтээгдэхүүнийг бусад үйлчилгээний урсгалд холбох.

Ийнхүү даатгалын салбарт өрнөж буй зах зээлийн өөрчлөлт, шинэчлэлтийг дагаж, дэлхийн даатгалын зуучлалын салбарт Fintech болон InsurTech технологи, онлайн платформ, хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн зөвлөх систем, автоматжуулсан харилцаа (chatbot) зэрэг инновациуд хүчтэй нэвтэрч байна.

Жишээлбэл:

- Европын улсуудад даатгалын зуучлагч нар цахим платформоор дамжуулан олон даатгагчийн бүтээгдэхүүнийг нэг дор харьцуулах боломжийг олгож байгаа бол,
- АНУ, Сингапур зэрэг улсад “Digital broker” буюу цахим зуучлагч тусгай зөвшөөрлийн дагуу ажиллаж, үйлчлүүлэгчийн зан төлөв, эрсдэлийн өгөгдөлд тулгуурлан хэрэглэгчид тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг автоматаар санал болгодог систем хөгжсөн байна.
- БНСУ, Япон зэрэг улсад даатгалын технологийн зохицуулалтын “sandbox” орчин бий болгож, шинэ төрлийн цахим зуучлалын үйл ажиллагааг туршиж байна.

Эдгээр чиг хандлага нь зөвхөн зуучлалын хэлбэрийг өөрчлөхөөс гадна зохицуулалтын шинэ стандарт, хяналтын механизмыг шаардаж, даатгалын салбарыг илүү нээлттэй, мэдээллийн их өгөгдөлтэй, хэрэглэгч төвтэй болгож байна.

Монгол Улсын хувьд даатгалын зуучлалын салбарын цаашдын хөгжил дараах чиглэлд төвлөрч ажиллах нь зүйтэй байна:

1. Мэргэжлийн стандартыг шинэчлэх буюу Даатгалын зуучлагчдын ёс зүй, мэргэжлийн ур чадвар, сургалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах.
2. Цахим зуучлалын эрх зүйн орчныг сайжруулах: Аппликэйшн, онлайн платформоор даатгалын бүтээгдэхүүн борлуулах үйл ажиллагааг “цахим даатгалын зуучлагч” ангиллаар хуульчлан тодорхойлох.
3. Өгөгдөлд суурилсан бодлого боловсруулах: Зах зээлийн мэдээлэл, хэрэглэгчийн зан төлөв, эрсдэлийн статистикийг ашиглан даатгалын бүтээгдэхүүн, тариф, сурталчилгааны бодлогыг шинэлэг хэлбэрт оруулах.
4. Хэрэглэгчийн итгэлцлийг нэмэгдүүлэх: Ил тод байдлыг хангах, гомдол шийдвэрлэх механизмыг сайжруулах замаар хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлогыг чангатгах.
5. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх: Бүс нутгийн болон дэлхийн даатгалын зуучлалын холбоод, байгууллагуудтай туршлага солилцох, хамтарсан сургалт, судалгааг дэмжих.

Дэлхийн даатгалын салбар “үйл ажиллагаа төвтэй” загвараас “эрсдэл ба хөрөнгийн менежмент төвтэй” стратегийн бизнесийн загвар руу шилжиж байна. Борлуулалт, нөхөн төлбөр зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг мэргэшсэн байгууллага, үйлчилгээ үзүүлэгчдэд даатгаж, харин даатгалын компаниуд өөрсдийн гол өрсөлдөх чадвар болох эрсдэлийн үнэлгээ, хөрөнгө удирдлага, инновацад төвлөрөх нь салбарын үр ашиг, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болж байна. Энэхүү өөрчлөлтийн гол тулгуур нь даатгалын зуучлал бөгөөд Монгол Улсын хувьд уг салбарыг шинэ шатанд гаргахын тулд технологийн дэвшил, зохицуулалтын шинэчлэл, хүний нөөцийн хөгжлийг хослуулах бодлогын цогц арга хэмжээ авах шаардлагатай байна. Цаашид даатгалын зуучлагчид зөвхөн бүтээгдэхүүн борлуулагч бус, харин эрсдэлийн зөвлөх, хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн даатгалын зөв шийдлийн архитектор болгон хөгжүүлэх нь даатгалын салбарын ирээдүйн хөгжлийн гол түлхүүр юм.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ЦАХИМ ЗАЛИЛАНГИЙН ГЭМТ ХЭРГИЙГ БУУРУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ ЭХЭЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо нь иргэд, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, мэдлэг мэдээлэл түгээх чиг үүргийнхээ хүрээнд Цагдаагийн ерөнхий газар, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, санхүүгийн салбарын 11 мэргэжлийн холбоотой хамтран цахим залилангийн гэмт хэргийг бууруулах, иргэдийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх нэгдсэн арга хэмжээ “Хашир бай” аяныг улсын хэмжээнд эхлүүлээ.

Энэхүү арга хэмжээний хүрээнд цахим болон санхүүгийн залилангийн тоог 2030 он гэхэд 3 дахин бууруулах, иргэд олон нийтийн хуурамч мэдээллийг таних чадварыг 20 хувиар нэмэгдүүлэх зорилготой. Ингэхдээ цахим орчин дахь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх сургалт, мэдээллийн тогтолцоог үе шаттайгаар бүрдүүлэх, үүрэн холбооны операторуудтай хамтран сэжигтэй линк, дуудлагыг автоматаар хаах зэрэг кибер аюулгүй байдлын нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Мөн иргэдийн санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, олон нийтийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулна.

Энэ оны эхний 10 сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт 41,844 гэмт хэргийн 14,694 буюу 35.1 хувь нь залилах гэмт хэрэг эзэлж байна. Үүнээс цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг нь 10,637 бөгөөд үүний 85.3 хувь нь санхүүгийн залилах гэмт хэрэг бөгөөд нийт 19.1 тэрбум төгрөгийн хохирол учиржээ. Цахим орчинд үйлдэж буй

гэмт хэргийн дийлэнх нь фэйсбүүк хаяг ашиглаж мөнгө шилжүүлэхийг хүссэн, телеграмаар даалгавар биелүүлж ашиг олохыг амлах, зээлийн эрх нэмэгдүүлэх нэрээр мэдээлэл авах зэрэг хэлбэр эзэлдэг.

БЛОКЧЕЙН СУУРЬТАЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭЧЛЭЛЭЭ СИНГАПУРЫН ФИНТЕК ФЕСТИВАЛЬД ТАНИЛЦУУЛАВ



Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн Сингапурын финтек фестиваль 2025–д оролцож, “Блокчейн технологид суурилсан биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны шинэчлэл” сэдвээр илтгэл тавилаа. Тэрээр илтгэлдээ Монгол Улсын биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог блокчейн технологид бүрэн шилжүүлсэн шинэчлэлийн талаар танилцуулж, шийдлийн зорилго, тулгарсан сорилт, туршилтын үе шат болон хүрсэн бодит үр дүнгийн талаар мэдээлэл өгсөн юм. Энэхүү шинэчлэлийн үр дүнд биржийн бус зах зээлийн арилжааны төлбөр тооцоо түргэн, шуурхай хийгдэх, мөн өдрийн зургаан цагаар хязгаарлагддаг байсан арилжааг 24/5 тасралтгүй явуулах, хөрөнгө оруулагчдад бодит цагийн, ил тод, нээлттэй орчин бий болж буйгаараа онцлогтой. Ингэснээр Монгол Улс энэхүү шийдлийг нэвтрүүлсэн дэлхийд анхдагч орнуудын нэг болж байна.

Мөн тэрээр энэ өөрчлөлт нь зөвхөн технологийн дэвшил төдийгүй хөрөнгийн зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд ойртуулах чухал алхам болохыг дурдаад, цаашдын зорилтуудыг танилцуулав.

Жил бүр зохион байгуулагддаг Сингапурын финтек фестиваль ньэнэ жил 10 дахь удаагаа зохион байгуулагдаж буй бөгөөд дэлхийн 130 гаруй улсын бодлого боловсруулагч, Төв банк, зохицуулагч байгууллага, финтек компани, хөрөнгө оруулагч болон салбарын төлөөллүүдийн 65 мянга гаруй оролцогчийг нэг дор цуглуулж, финтекийн салбарын сүүлийн үеийн технологи, дэвшил, чиг хандлага болон бодлого, зохицуулалтын онцлох шийдлүүдийг танилцуулж, хэлэлцэх боломжийг олгодог олон улсын томоохон арга хэмжээний нэг юм.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДЭД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбарын оролцогчдын чадавхыг бэхжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хариуцлагын тогтолцоог сайжруулах, мэдээлэл мэдлэгийг түгээх зорилгоор сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Энэ хүрээнд Баянхонгор аймагт үнэт металл, үнэт чулуу болон эдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид мөн бичил уурхай эрхлэгчдэд зориулсан сургалтыг 11 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулла. Сургалтын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, зохицуулалтын чиг хандлагын талаар танилцуулж, оролцогчдоос тулгамдаж буй асуудлуудыг сонсож, харилцан санал солилцов.

Мөн тус аймаг дахь Монголбанк болон арилжааны банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, тухайн бүс нутагт үнэт металлын арилжааны хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцсон юм.

ЖУРМЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооноос “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулж салбарын байгууллагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүллээ.

Хэлэлцүүлгийн үеэр журмын нэмэлт, өөрчлөлтийн гол агуулга, зорилтын талаар танилцуулж, оролцогч байгууллагуудтай санал солилцов. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, жижиг, дунд бизнесийг дэмжих, салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой юм. Тодруулбал банк бус санхүүгийн байгууллагуудын бусдаас татах эх үүсвэрийн зохистой харьцаанд өөрчлөлт оруулах замаар ногоон санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх, бизнесийн зээлийн хэмжээг өсгөх, хямд өртөгтэй хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдэхээр байна. Энэ нь салбарын хөгжлийг дэмжиж, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой юм.

Мөн энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлын талаар мэдээлэл өгч, оролцогчдын саналыг сонслоо.

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт салбарын 100 гаруй байгууллагын төлөөлөл оролцсон юм.



ЯРИЛЦЛАГА

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР ДАХЬ НОГООН САНХҮҮЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ



*Хадгаламж, зээлийн хоршооны газрын референт
К.Булбултай ярилцлаа.*

ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх” төслийг эхлүүлээд байна.

Төсөл хэрэгжүүлснээр ямар үр дүн гарах вэ?

Уур амьсгалын өөрчлөлтөд эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийнхэн хамгийн ихээр өртдөг бөгөөд санхүүгийн үйлчилгээнд хүрэхэд олон саадтай тулгардаг. Төслийн үр дүнд хадгаламж, зээлийн хоршоод ногоон санхүүгийн бүтээгдэхүүнтэй болж, гишүүдийн дунд ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг нэмэгдэх, ногоон санхүүжилтийн хэрэглээг бий болгох, хадгаламж, зээлийн хоршоодын гишүүн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, ялангуяа эмэгтэйчүүд байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдэж, ногоон санхүүжилт татахад хялбар болж, тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулахаас гадна ногоон санхүүжилтийн санаачилгыг дэмжсэн бодлого, зохицуулалтын орчин бэхжих юм. Хамгийн чухал нь ногоон бүтээгдэхүүнтэй болсноор хадгаламж, зээлийн хоршоод санхүүжилт авах боломж нээгдэнэ.

Олон улсын сүүлийн үеийн мэдээллээс хуваалцвал?

Энэ оны 10 дугаар сард Папуа Шинэ Гвинейд Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс зохион байгуулсан “Тогтвортой ногоон санхүүжилт” сургалтад миний бие оролцоод ирлээ. Сургалт, уулзалтаар улс орнууд өөрсдийн туршлага, бодлогын хэрэгжилт, дижитал санхүүгийн үйлчилгээг ногоон болон хүйсийн мэдрэмжтэй болгох бодлого боловсруулан хэрхэн ашиглаж байгаа талаараа хуваалцлаа.

Папуа Шинэ Гвиней улсын талаар ярьж л даа. Сүүлийн

Танд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 3 дугаар сард ярилцсан шүү дээ. ХЗХ-ны ногоон санхүүгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөв? Сүүлийн үеийн ахиц дэвшлүүдийн талаар ярьвал?

Монгол Улс 2019 онд Ногоон таксономиг баталснаараа бүс нутагтаа анхдагчдын нэг болж байсан бол түүнээс хойш бусад улсууд мөн Ногоон таксономийг батлаад зогсохгүй дараагийн хувилбаруудаа баталж, санхүүгийн салбар гэлтгүй бүх салбарт өргөн ашиглаж байна. Эх газрын орнуудад Ногоон таксономийг хэрэгжүүлж байхад далай болон усны нөөцөд суурилсан орнууд тогтвортой эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлох, ангилал, үнэлэх зорилготой санхүүгийн Цэнхэр таксономийг баталж, усан орчны тогтвортой байдал, далайн экосистемийн хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Манай хадгаламж, зээлийн хоршооны салбарын хувьд өнгөрсөн хугацаанд ногоон санхүүгийн нөхцөл байдал мөн ахиц дэвшил гарсан. Тухайлбал 2025 оны 9 дүгээр сараас Хороо Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)–тэй хамтран “Хадгаламж, зээлийн хоршоодын хүртээмжтэй

жилүүдэд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор ногоон санхүүжилтийн тогтолцоог эрчимтэй хөгжүүлж байна. 2023 онд тус улс “Олон нийтийг хамарсан ногоон таксономи” буюу “Хүртээмжтэй ногоон таксономи”-г баталсан нь санхүүгийн урсгалыг байгаль орчинд ээлтэй, нийгмийн хувьд хүртээмжтэй байдлаар ангилах, хянах, тайлагнах үндэс суурийг бүрдүүлсэн. Энэхүү таксономи нь ногоон болон цэнхэр санаачилгууд, нийгэмд ээлтэй зээл, тогтвортой байдалтай холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангах шаардлагуудыг багтаасан бөгөөд үндэсний хөгжлийн бодлого болон НҮБ-ын уур амьсгалын зорилтуудтай уялдуулан боловсруулагдсан байна.

Үүнтэй зэрэгцэн, 2024 онд Порт Морсби хотод Төв банкны дэргэд “Ногоон санхүүжилтийн төв” байгуулагджээ. Энэхүү төв нь Францын Хөгжлийн төв, Шинэ Зеландын Гадаад хэргийн яам, Дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэн зэрэг олон улсын түншүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа бөгөөд үндэсний хэмжээнд ногоон санхүүгийн бодлогыг удирдан зохицуулах, банк болон бичил санхүүгийн байгууллагуудтай хамтран ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, мөн ногоон баталгааны сан болон дахин санхүүжилтийн механизм бий болгох үүрэгтэй.

Ногоон санхүүгийн бодлогын хүрээнд “Хүртээмжтэй ногоон санхүүгийн бодлого”-ыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ногоон таксономи, хэрэгжилтийн замын зураглал болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг уур амьсгалд ээлтэй салбар руу чиглүүлэх стратегиудыг багтаасан байна. Хөдөө аж ахуй, тогтвортой загасны аж ахуй, эмэгтэйчүүдийн бизнес, сэргээгдэх эрчим хүч, REDD+ буюу “Ойн доройтол, ой тайралтаас үүдэлтэй ялгарлыг бууруулах” хөтөлбөр, тээврийн шинэчлэл зэрэг салбарт чиглэсэн ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж байна.

Папуа Шинэ Гвинейн бичил санхүүгийн салбарт MiBank, Mama Bank, BSP Group зэрэг байгууллагууд хүртээмжтэй ногоон санхүүгийн бодлогын хүрээнд ногоон зээлийн бүтээгдэхүүн туршиж, тайлагналын системийг боловсруулж, хадгаламж, зээлийн хоршоодын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор техникийн туслалцаа, сургалт, урамшууллын механизм хэрэгжүүлж байна. Эдгээр санаачилгууд нь ногоон санхүүжилтийн тогтолцоог илүү хүртээмжтэй, үр дүнтэй болгоход чиглэж байгаа юм.

Бичил санхүүгийн салбарт ажиллаж буй байгууллагуудын жишээнээс дурдвал?

Жишээлбэл, Mama Bank буюу эмэгтэйчүүдэд зориулсан бичилсанхүүгийн банк нь ногоон санхүүжилт, эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмж, уур амьсгалын эрсдэлийн даатгалын чиглэлээр түүчээлсэн шинэчлэлүүдийг авчирсан. Мөн ногоон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд өөрсдийн үйл ажиллагааны зардал болон бусад зардлуудыг хэмнэснээр хямд өртөгтэй санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж байна. Тус банк нь хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд хүрч үйлчлэх зорилгоор биометрийн технологид суурилсан “Эмэгтэйчүүдийн нэвтрэх бүс”-ийг нэвтрүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг эрс нэмэгдүүлсэн. Мөн НҮБ-тай хамтран зээлийн баталгааны механизм хэрэгжүүлж, эмэгтэйчүүдийн бичил бизнесүүдэд зориулсан зээлийн нөхцөлийг хөнгөвчилснөөр барьцааны шаардлагыг бууруулж, хүүг багасгах, хадгаламжийн доод хязгаарыг цуцлах зэрэг давуу талуудыг бий болгосон.

2024 онд Mama Bank нь далайн эерэг нөлөө бүхий бичил бизнесүүдийг дэмжих зорилгоор Цэнхэр эдийн засгийн баталгаа (Blue Economy Guarantee) хөтөлбөрийг эхлүүлж, нэг сая ам.долларын баталгааны санг байгуулсан. 2024 оны байдлаар Mama Bank 293 эмэгтэй болон 29 залуучуудын бичил бизнест нийт 295,000 ам.долларын зээл олгосон бөгөөд зээлийн дундаж хэмжээ 902 ам.доллар, хугацаа нь 3–15 сар байсан. Эдгээр шинэчлэлүүд Папуа Шинэ Гвинейн бичил санхүүгийн салбарт бүтцийн саад тотгорыг арилгаж, өмнө нь санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байсан иргэдийг хамруулж, ногоон, хүртээмжтэй санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд түүчээлсэн алхмууд болсон гэх мэт гадны туршлагаудаас санаа аваад цаашид хөгжих боломж бидэнд байна.


Мэдээлэл өгч ярилцсанд баярлалаа, ТАНД цаашдын ажилд нь амжилт хүсье.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН 2025 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн Банкны Санхүүгийн Тогтвортой Хөтөлбөрийн хүрээнд тогтвортой бондын зах зээлийн чиг хандлага тайланг 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хүргэж байна. Тогтвортой бондын зах зээлийн голлох бүтээгдэхүүн болох ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, тогтвортой байдалтай уялдсан бонд, шилжилтийн бондын нийт хуримтлагдсан хэмжээ 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 6.59 их наяд ам.долларт хүрлээ. 2025 оны 3 дугаар улиралд тогтвортой бондын нийт хэмжээ буурсан ба энэ нь 2020 оноос хойших хамгийн бага түвшинд хүрсэн юм. 2025 оны эхний есөн сарын (I–IX сар) хугацаанд нийт 683.4 тэрбум ам.долларын бонд


Зураг. Тогтвортой бондын гаралт 2016–2025 /тэрбум ам.доллар/



Source: World Bank based on Environmental Finance Data


гаргасан бөгөөд үүний 60.7 хувийг ногоон бонд эзэлсэн нь зах зээлд байгаль орчны чиглэл давамгайлж байна.

Зураг. Зах зээл болон бондын төрлөөр ангилсан тогтвортой бондын нийт хуримтлагдсан дүн, тэрбум ам.доллар



Source: World Bank based on Environmental Finance Data


Зураг– Зах зээл болон бонд гаргагчийн төрлөөр ангилсан тогтвортой бондын хуримтлагдсан дүн, тэрбум ам.доллар



Source: World Bank based on Environmental Finance Data

Тайлант хугацаанд бондын зах зээлийн идэвх буурсан хэдий ч хөгжиж буй улс орнуудын (EM) тогтвортой бондын гаргалт өндөр хэвээр буюу нийт бондын 14%-ийг бүрдүүлж байна. Ногоон бондын гаргалт нь хөгжиж буй улс орнуудын зах зээл болон хөгжингүй зах зээлүүдэд (AM) хоёуланд нь давамгайл байж, тус бүр нийт хуримтлагдсан дүн 67% болон 66%-ийг эзэлж байна. Хөгжиж буй тусгаар улс, тэдний төрийн агентлагууд, хотын захиргаа, орон нутгийн болон бүс нутгийн засаг захиргааг багтаасан төрийн секторын оролцоо бондын нийт зах зээлийн 27%-ийг эзэлдэг бол хөгжингүй орнуудын (AM) бондын зах зээлд энэ үзүүлэлт 42%-тай байна.

Зураг. Бонд гаргагчийн төрлөөр ангилсан тогтвортой бондын улирлын гаргалт, тэрбум ам.доллар




Source: World Bank based on Environmental Finance Data

2025 оны 3 дугаар улирлын гүйцэтгэл:

2025 оны 3 дугаар улиралд нийт 192.5 тэрбум ам.долларын бонд гарсан нь 2025 оны 2 дугаар улирал болон 2024 оны 3 дугаар улирлаас тус бүр 13.6% ба 29.6%-иар тус тус буурсан үзүүлэлт юм. Мөн улирлын гүйцэтгэлээр бонд тус бүрийн гүйцэтгэл өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс буурсан бөгөөд ногоон бонд 24.5%, нийгмийн бонд 68.2%, тогтвортой байдлын бонд 6.1%, тогтвортой байдалтай уялдсан бонд 72.1% болон шилжилтийн бонд 10.6%-иар тус тус буурсан. Мөн 2025 оны 3 дугаар улиралд гарсан бондыг зах зээлээр нь авч үзвэл 2024 оны мөн үетэй харьцуулахад хөгжингүй орнуудын бонд 31.9%, хөгжиж буй орнуудын бонд 44.7% тус тус буурсан байна.

2025 оны 9 дүгээр сарын байдлаар хөгжиж буй орнууд дундаас Чили Улс хамгийн өндөр дүнтэй бонд гаргасан улс бөгөөд нийт 55 тэрбум ам.долларын ногоон, нийгмийн, тогтвортой байдлын, тогтвортой байдалтай уялдсан бондууд гаргажээ.

Харин түүний араас Мексик Улс 28 тэрбум ам.доллар, Тайланд Улс 22 тэрбум ам.долларын бонд гаргасан үзүүлэлтээр удаалж байна.



Source: World Bank based on Environmental Finance Data

Зах зээлийн дүн шинжилгээ:

- Ногоон бонд нь тогтвортой бондын зах зээлд эзлэх хувийг тэргүүлж, хөрөнгө оруулагчдын эрэлт тасралтгүй өсч байна.
- Нийгмийн болон тогтвортой байдалтай уялдсан бондууд өмнөх улирлуудтай харьцуулахад саарсан үзүүлэлттэй гарчээ.
- Зах зээлийн идэвх буурсан шалтгаан нь дэлхийн макро эдийн засгийн тогтворгүй байдал, хүүгийн түвшин өссөн, мөн зарим бүс нутгийн бодлогын тодорхой бус байдалтай холбоотой байна.

Гэсэн ч, нийт хуримтлагдсан бондын хэмжээ түүхэн дээд түвшинд хүрсэн нь тогтвортой санхүүжилтийн чиглэлд хөрөнгө оруулагчдын сонирхол урт хугацаанд тогтвортой хэвээр байгааг харуулж байна.

Эх сурвалж: World Bank. (2025, October). Labeled sustainable bonds: Quarterly market update (Q3). World Bank Group.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ISO 26000 НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН УДИРДАМЖ

Өнөө үед олон улсын харилцаа, улс төр, хөрөнгө оруулалт, бизнес худалдаанд цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, эдийн засгийг тогтвортой хөгжилд чиглүүлэх асуудал чухал байр суурь эзлэх болоод удаж байна. 2015 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас (НҮБ)–аас хоорондоо уялдаа холбоо бүхий тогтвортой хөгжлийн 17 зорилт батлан хэрэгжүүлж эхэлсэн нь дэлхий нийт болон бүс нутгийн хэмжээнд тулгамдсан олон асуудлуудыг шийдвэрлэхэд хувийн хэвшлийн оруулах хувь нэмрийг чухалчлан авч үзэх болсныг илтгэж байна.

Монгол Улсын хувьд бэлчээрийн доройтол, цөлжилт, ган, зуд, агаар, ус, хөрсний бохирдол, улирлын чанартай ой хээрийн түймэр зэрэг тогтвортой хөгжлийн олон асуудлууд нүүрлэсээр байна. Эдгээр асуудлууд нь улсын эдийн засаг, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх нь жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа хамгийн их шаардлагатай байгааг харуулдаг. Энэ чиглэлээр бизнес эрхлэгчид компанийн нийгмийн хариуцлага, ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр өөрсдийн санал санаачилгыг гаргадаг нь сайшаан үнэлүүштэй боловч тэдэнд нийгмийн хариуцлага гэх өргөн хүрээг хамарсан асуудлын талаар үндэслэл суурьтайгаар зөвлөн туслагч төдийлөн байдаггүй.

Энэхүү нөхцөл байдлыг засах зорилгоор 2010 онд Олон улсын стандартын байгууллагаас “ISO 26000 Нийгмийн хариуцлагын удирдамж”–ыг баталсан бөгөөд энэ нь компаниудад нийгмийн хариуцлагын талаарх чиг баримжаа өгөх зөвлөмж юм. Тухайлбал, уг удирдамж нь компаниудад өөрсдийн үйл ажиллагаандаа нийгэм, эдийн засаг болон байгаль орчинтой холбоотой хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар жишиг бий болгож, тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмэр оруулахад туслахад чиглэдэг.

Нийгмийн хариуцлагын удирдамжийг ашгийн төлөө, ашгийн бус, төрийн болон төрийн бус ямар ч төрлийн байгууллагад нэвтрүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд “удирдамж” хэлбэрээр батлагдсан тул бусад ISO стандартуудын адил гэрчилгээ олгогддоггүй, сайн дурын шинжтэй байдаг.

ISO 26000 нь дараах долоон бүрдэл хэсэг буюу үндсэн хүрээг хамардаг. Үүнд:

- 1. Байгууллагын засаглал.** Энэ нь компанийн удирдлагын түвшинд ёс зүйн хариуцлагатай шийдвэр гаргаж, гаргасан шийдвэр ил тод байхад чиглэсэн зарчмуудыг багтаадаг.
- 2. Хүний эрх.** Ажлын байрны таатай орчныг бүрдүүлэхээс эхлэн нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхийн зөрчил гарахаас сэргийлэх хүртэлх компанийн үйл ажиллагааны бүх үе шатанд хүний эрхийг дээдлэхэд чиглэнэ.
- 3. Хөдөлмөрлөх нөхцөл.** Энэ хүрээнд цалин урамшууллын тогтолцоог шударга болгож, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ажлын байран дахь эрх тэгш байдлыг хангах зэрэг асуудлуудыг шийдвэрлэнэ.
- 4. Байгаль орчны хамгаалал.** Бизнесийн үйл ажиллагааны стратегийн түвшинд байгаль орчинд эрсдэл багатай арга хэлбэрийг нэвтрүүлж, гадагш учруулах хор аюулыг багасгахад анхаардаг.
- 5. Бизнесийн шударга байдал.** Энэ нь бизнесийн үйл ажиллагаанд ёс зүйг хэвшүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, шударгаар өрсөлдөх, нийлүүлэлтийн сүлжээнд хариуцлагыг бий болгохыг хэлнэ.
- 6. Хэрэглэгчийн эрх ашиг.** Бүтээгдэхүүн үйлчилгээний аюулгүй байдал, тэдгээрийн талаарх мэдээллийн ил тод байдал, хэрэглэгчтэй харилцах үйл ажиллагааг сайжруулахад анхаардаг.
- 7. Нийгмийн оролцоо ба хөгжил.** Эцэст нь, компани бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа газар нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд хариуцлагатай байдлаар хувь нэмэр оруулна.

Дээр дурдсан бүрдэл хэсэг бүр нь компанид нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагын талаар тодорхой зааварчилгаа болох төдийгүй байгууллагад илүү ил тод, хариуцлагатай,

ёс зүйтэй байдлаар үйл ажиллагаагаа явуулахад нь түлхэц болдог.

Афнор группээс 2019 оны сүүлээр зохион байгуулсан судалгаанд нийгмийн хариуцлагын удирдамж ISO 26000–ыг нэвтрүүлснээр 400 гаруй компанийн үйл ажиллагаанд гарсан эерэг өөрчлөлт, үр дүнгийн талаар тодорхой хариултууд өгсөн байна. Үүнд:

- Имиж. Судалгаанд хамрагдсан компаниудын 80 хувь нь ажилтнуудын хариуцсан ажилдаа хандах хандлага сайжирч, ажлын байранд өрсөлдөх нэр дэвшигчдийн тоо нэмэгдсэн гэж хариулсан.
- Үйл ажиллагааны бүтээмж. Судалгаанд оролцсон компаниудын 78 хувь нь нийгмийн хариуцлага нь инновацыг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог гэж хариулсан бол 75 хувь нь үйл ажиллагааны ондоошлыг бий болгодог гэжээ.
- Борлуулалт. Нийт компанийн 38 хувийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулсны орлого нэмэгдсэн гэж үзсэн.
- Ашиг. Судалгаанд оролцсон компаниудын 40 хувь нь үйл ажиллагааны ашиг нэмэгдсэн гэж хариулсан.

Компанидаа ISO 26000–ыг дараах үе шаттайгаар нэвтрүүлж болно. Тухайлбал:

- Юуны өмнө уг удирдамжид багтсан нийгмийн хариуцлагын үндсэн зарчмуудтай танилцаж, тэдгээр нь компанийн бизнесийн үйл ажиллагаатай хэрхэн уялддагийг ойлгож авах шаардлагатай. Энэ нь цаашид бизнесийн үйл ажиллагааг хариуцлагатай явуулахад бодит үндэс суурь болно.
- Дараагийн алхам бол компанийн нийгмийн хариуцлагын нөлөөллийн хүрээг тодорхойлох юм. Тухайлбал, компанийн үйл ажиллагаа нь нийгэм,

байгаль орчин болон бусад оролцогч талуудад хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх хэрэгтэй.

- Үүний дараа ажилтнууд, хэрэглэгчид, нийлүүлэгчдээ идэвхтэй оролцуулж, тэдний санаа оноо, хүлээлтийг илүү сайн ойлгож авах шаардлагатай. Ингэснээр тухайн компани нь нийгмийн хариуцлагатай холбоотой үйл ажиллагаагаа илүү оновчтой төлөвлөж чадна.
- Нийгмийн хариуцлагыг компанийн бодлогод нэгтгэж, байгууллагын соёлын нэг хэсэг болгох хэрэгтэй. Ингэснээр нийгмийн хариуцлага компанийн үйл ажиллагааны бүх түвшинд тусгагдана.
- Компанийнхаа дотоод чадамжийг бий болгож, ажилтнуудаа сургаж, нийгмийн хариуцлагыг бодит үйлдлээр хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хэрэгслээр хангах хэрэгтэй.
- Бизнесийн үйл ажиллагаанд ил тод, тогтмол харилцаа чухал байдаг. Иймд компанийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг ил тодоор мэдээлэх хэрэгтэй.
- Эцэст нь, нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг хянаж, үнэлнэ. Энэ үе шатанд компанийн бодлого зорилго, нийгмийн өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад компаниас явуулж байгаа нийгмийн хариуцлагын арга хэмжээ нийцэж байгаа эсэхийг нягталж, шаардлагатай тохиолдолд сайжруулалт, тохируулгыг тогтмол хийнэ.

Дээрхээс үзвэл, ISO 26000 нь зөвхөн компанийн удирдлагын түвшинд нийгмийн хариуцлагын баримжаатай шийдвэр гаргахад хэрэглэх арга хэрэгсэл төдийгүй байгууллагын урт хугацааны амжилт, тогтвортой өсөлтийг хангах чухал стратегийн баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, компани нь нийгмийн хариуцлагыг системтэйгээр, олон улсын жишигт нийцүүлэн нэвтрүүлснээр зах зээлийн өрсөлдөөнд байр сууриа хадгалж, бизнесийн нэр төрөө өсгөх боломж бий болдог ажээ.

Эх сурвалж:

<https://www.boreal-is.com/blog/iso-26000-social-responsibility/>

<https://www.afnor.org/en/sustainable-development/iso-26000-approach/>

<https://plana.earth/academy/iso-26000>

ФИНТЕК БА РЕГТЕК

ШИЛДЭГ 10: ЗЭЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН (LENDTECH) ПЛАТФОРМУУД

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ дэлхийн шилдэг 10 зээлийн технологийн платформыг танилцуулахаар бэлтгэлээ. Зээлийн технологийн салбар нь сүүлийн жилүүдэд санхүүгийн үйлчилгээний тогтолцоонд томоохон шинэчлэл авчирч, зах зээлийн хэмжээ 2024 онд 15.7 тэрбум ам.доллар байсан бол 2034 он гэхэд 145.1 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Хойд америкийн бүс нутагт зах зээлийн 38 хувийг бүрдүүлж байгаа ч Ази–Номхон далайн бүс хурдтай өргөжин тэлж байна. Эдгээр платформууд нь уламжлалт зээлийн үнэлгээний аргачлалыг шинэ түвшинд хүргэж, хөдөлмөр эрхлэлт, боловсролын мэдээлэл болон бизнесийн бодит цагийн үзүүлэлт зэрэг олон талын өгөгдлийг ашигласнаар зээлдэгчийн эрсдэлийг илүү нарийвчлалтай тогтоох боломжийг бүрдүүлж байна. Мөн энэ салбар нь P2P зээлийн зах зээл зэрэг олон төрлийн зээлийн шийдлийг багтааж, дэлхийн хэмжээнд хэрэглэгч болон жижиг бизнесүүдийн санхүүжилтэд хандах боломжийг өргөжүүлж байна. Энэхүү мэдээллийг Fintech magazine–аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

FUNDBOX



Гүйцэтгэх захирал: Prashant Fuloria

Үүсгэн байгуулсан он: 2013

Байршил: Сан Франциско, Калифорни, АНУ

Fundbox нь хиймэл оюун ухаанд суурилсан санхүүгийн платформоороо дамжуулан жижиг бизнесүүдийн мөнгөн урсгалын удирдлагад шинэчлэл авчирч, зээлийн шугам болон хугацаат зээл зэрэг санхүүжилтийн шийдлүүдийг санал болгодог. Тус компани нь бизнесийн үйл ажиллагааг үнэлж, зээл авах боломжийг автоматаар тогтоохын тулд өөрийн боловсруулсан алгоритмуудыг ашигладаг. Анх Eyal Shinar, Tomer Michaeli болон Yuval Ariav нар байгуулсан бөгөөд капитал платформ хэлбэрээр эхэлсэн Fundbox нь өнөөдөр иж бүрэн B2B санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болж өргөжсөн. Платформ нь бодит цагийн мэдээлэлд тулгуурлан зээлийн хүсэлтийг боловсруулж, АНУ даяарх жижиг бизнесүүдэд хурдан шийдвэр гаргах боломжийг бүрдүүлдэг.

AVANT



Гүйцэтгэх захирал: Matt Bochenek

Үүсгэн байгуулсан он: 2012

Байршил: Чикаго, Иллинойс, АНУ

Avant нь зээл авах боломж бага буюу дундаж кредит оноотой зээлдэгчдэд зориулсан хувийн зээл, кредит картын үйлчилгээ санал болгодог бөгөөд уламжлалт зээл олголтын зах зээл дэх чухал орон зайг нөхөж ажилладаг. Albert Goldstein, John Sun, Paul Zhang нарын үүсгэн байгуулсан тус компани нь уламжлалт кредит мэдээллийг машин сургалтын алгоритм болон аналитик хэрэгслүүдтэй хослуулан ашиглаж, хэрэглэгч бүрт тохирсон зээлийн нөхцөлийг тодорхойлдог.

Технологид суурилсан Avant–ийн арга барил нь компанид АНУ–ын 46 мужид зээл олгох боломжийг бий болгож, Канад болон Их Британид үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд хүргэсэн. Платформын үндсэн чиглэл нь “mid–prime” сегментэд төвлөрсөн зээл олголт бөгөөд хэрэглэгчдэд хурдан, хялбар онлайн өргөдлийн үйл явцыг санал болгодог.

OnDeck



OnDeck нь бизнесийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн боловсруулдаг өөрийн дотоод програм хангамжийг ашигласнаар алгоритмд суурилсан зээлийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлж, жижиг бизнесийн онлайн зээл олголтын салбарыг үндэслэгчдийн нэг юм. Mitch

Jacobs–ийн үүсгэн байгуулсан тус компани нь зөвхөн онлайн сувгаар хугацаат зээл олгодог, нөхцөл ба төлөлтийн сонголтыг хэрэглэгчид тохируулан өөрчлөх боломжтой шийдлүүдийг санал болгодог тэргүүлэх шууд зээлдүүлэгч болж өргөжив. OnDeck нь

2014 онд IPO хийж, улмаар 2020 онд Enova International компанид худалдагдсан. Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш жижиг бизнесүүдэд нийт 13 тэрбум ам.доллараас дээш санхүүжилт олгосноороо альтернатив зээлийн салбарын түлхүүр тоглогчдын нэг болж чадсан.

Kabbage



Гүйцэтгэх захирал: American Express-ийн бүрэлдэхүүн (2020 онд худалдан авсан)

Үүсгэн байгуулсан он: 2009

Байршил: Атланта, Жоржиа, АНУ

Анх Rob Frohwein, Kathryn Petralia, Marc Gorlin нарын байгуулсан Kabbage нь жижиг бизнесүүдэд зориулсан зээл олголтыг бодит цагийн мэдээллийн шинжилгээ болон автоматжуулсан үнэлгээний системээр шинэ шатанд гаргасан. Тус компани уламжлалт кредит үнэлгээнээс илүүтэйгээр бизнесийн гүйлгээний мэдээлэлд тулгуурлан 250,000 ам.доллар хүртэлх зээлийг санал болгодог байв. American Express компани 2020 онд Kabbage-ийг ойролцоогоор 850 сая ам.доллараар худалдан авч, түүний технологийн платформыг өөрийн санхүүгийн экосистемд нэгтгэсэн. Үүний дараа платформыг 2023 онд American Express Business Blueprint хэмээн дахин нэрлэж, АНУ даяарх жижиг бизнесүүдэд зориулсан дижитал мөнгөн урсгалын шийдлүүдийг үргэлжлүүлэн хүргэж байна.

Lendio



Гүйцэтгэх захирал: Brock Blake

Үүсгэн байгуулсан он: 2011

Байршил: Лехи, Юта, АНУ

Lendio нь жижиг бизнесүүдийг 75 гаруй зээлийн байгууллагатай нэг дор холбодог АНУ-ын хамгийн өргөн хүрээтэй онлайн зээлийн marketplace юм. Brock Blake болон Trent Miskin нарын үүсгэн байгуулсан тус компани өнөөг хүртэл 400,000-аас илүү жижиг бизнест нийтдээ 16 тэрбум ам.доллараас давсан санхүүжилт авахад нь тусалжээ. Платформ нь хиймэл оюун ухааны технологийг ашиглан бизнес бүрийг хамгийн тохиромжтой санхүүжилтийн сонголттой автоматаар тааруулж, зээлд хамрагдах өргөдлийн хугацааг 25 цагаас ердөө 15 минут болгон богино болгосон. Мөн Lendio нь онлайн зээлийн салбарт франчайзын загварыг нэвтрүүлсэн анхдагчдын нэг бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан суурилсан маркетплейсийн шийдлүүдээ тогтмол шинэчилж, өргөжүүлсээр байна.

Affirm



Гүйцэтгэх захирал: Max Levchin

Үүсгэн байгуулсан он: 2012

Байршил: Сан Франциско, Калифорни, АНУ

Affirm нь АНУ-д BNPL буюу “одоо аваад дараа төл” үйлчилгээ үзүүлэгч хамгийн том компани юм. Тэд 22 сая хэрэглэгчтэй бөгөөд жил бүр 28 тэрбум ам.долларын гүйлгээ боловсруулдаг. PayPal-ийн үүсгэн байгуулагч Max Levchin болон Nathan Gettings, Jeffrey Kaditz, Alex Rampell нар 2012 онд байгуулсан энэ компани хэрэглэгчдэд ил тод, тогтмол төлбөртэй хэсэгчлэн төлөх боломж санал болгоход төвлөрдөг. Affirm нь хэрэглэгчийн зээлийн чадварыг үнэлэхдээ зөвхөн уламжлалт FICO оноонд найдахгүй, харин машин сургалтын технологи ашиглан илүү олон төрлийн мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргадаг. Энэ нь зээл, худалдан авалтад олон хүнд илүү боломж нээж өгдөг. Тус компани 2021 онд хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй гаргаж, Amazon, Apple, Target зэрэг томоохон жижиглэн худалдаачидтай түншлэн, хэрэглэгчдэд нууц нэмэлт хураамжгүй шударга санхүүгийн үйлчилгээ хүргэсээр байна.

Prosper Marketplace



Гүйцэтгэх захирал: David Kimball

Үүсгэн байгуулсан он: 2005

Байршил: Сан Франциско, Калифорни, АНУ

Prosper Marketplace нь АНУ-д peer-to-peer (P2P) зээл олголтыг анхлан нэвтрүүлсэн компани бөгөөд зээлдэгчдийг хувь хүн болон

байгууллагын хөрөнгө оруулагчидтай шууд холбодог анхны хэрэглээний зээлийн маркетплейсийг бий болгосон. 2016 оноос хойш гүйцэтгэх захирлаар ажиллаж буй David Kimball-ийн удирдлага дор тус платформ нь 23 тэрбум ам.доллараас давсан хувийн зээлийг зуучлан, 2,000–50,000 ам.долларын хэмжээтэй зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Тус компани энгийн P2P зээлээс цаашлан кредит карт, орон сууцны өмчлөлд суурилсан зээлийн шугам (home equity line of credit), мөн санхүүгийн төлөвлөлтийн иж бүрэн хэрэгслүүдийг хэрэглэгчдэдээ хүргэдэг болж өргөжжээ. Prosper-ийн өгөгдөлд суурилсан үнэлгээний систем нь зээлдэгчдэд өрсөлдөхүйц хүү санал болгохын зэрэгцээ хөрөнгө оруулагчдад янз бүрийн кредитийн түвшинд ашигтай өгөөж бий болгож өгдөг.

SoFi



Гүйцэтгэх захирал: Anthony Noto

Үүсгэн байгуулсан он: 2011

Байршил: Сан Франциско, Калифорния, АНУ

SoFi Technologies нь өндөр орлоготой хэрэглэгчдэд голлон чиглэсэн, дижитал санхүүгийн иж бүрэн платформ бөгөөд зээлдэгчдийн дундаж FICO оноо нь 749 байдаг. Анх Mike Cagney, Dan Macklin, James Finnigan, Ian Brady нарын байгуулсан тус компани оюутны зээлийн дахин санхүүжилтээс үйл ажиллагаагаа эхлүүлж, улмаар хувийн зээл, орон сууцны зээл, хөрөнгө оруулалтын үйлчилгээ болон банкны бүтээгдэхүүн хүртэл өргөжсөн. Гүйцэтгэх захирал Anthony Noto-ийн удирдлага дор SoFi нь банкны тусгай зөвшөөрөл авч, илүү хямд санхүүжилтийн эх үүсвэртэй болохын зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ хүрээг тэлэх боломжтой болсон. Тус платформ технологид суурилсан экосистемээрээ дамжуулан 2.5 сая гаруй хэрэглэгчид үйлчилж, олон төрлийн санхүүгийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой “нэг цэгийн санхүүгийн шийдэл” болж байр сууриа бататгасан.

Lending Club



Гүйцэтгэх захирал: Scott Sanborn

Үүсгэн байгуулсан он: 2007

Байршил: Сан Франциско, Калифорния, АНУ

LendingClub Corporation нь LendingClub Bank-ийн толгой компани бөгөөд хувийн зээл, бизнесийн зээл, авто зээлийн дахин санхүүжилт зэрэг өргөн хүрээний санхүүгийн бүтээгдэхүүнээр 4.8 сая гаруй хэрэглэгчид үйлчилдэг. P2P зээлийн салбарын анхдагч болох тус компани үүсгэн байгуулагдсанаасаа хойш 75 тэрбум ам.доллараас давсан зээл зуучилж, зээлийн шийдвэр гаргалтад дэвшилтэт машин сургалтын загваруудыг ашигладаг. Гүйцэтгэх захирал Scott Sanborn-ийн удирдлага дор LendingClub нь цэвэр marketplace моделээс бүрэн хэмжээний дижитал банк болж хөгжсөн бөгөөд өндөр өгөөжтэй хуримтлалын данс, бизнесийн банкны үйлчилгээ зэрэг бүтээгдэхүүнийг санал болгож зээл олголтын технологид суурилсан арга барилаа үргэлжлүүлэн хадгалсаар байна.

Upstart



Гүйцэтгэх захирал Dave Girouard

Үүсгэн байгуулсан он: 2012

Upstart

Байршил: Сан Матео, Калифорния, АНУ

Upstart Holdings нь хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн платформуороо дамжуулан уламжлалт FICO онооноос давсан шинэ түвшний зээлийн үнэлгээний аргачлалыг нэвтрүүлж дэлхийн lendtech салбарт тэргүүлэгчээр тодорсон компани юм. Google-ийн удирдах албан тушаалтнууд байсан Dave Girouard, Anna Counselman, Paul Gu нарын үүсгэн байгуулсан тус компани хэрэглэгчдийг 100 гаруй банк болон хадгаламж, зээлийн хоршоодтой өөрийн AI моделийн тусламжтайгаар холбодог. Upstart нь нийт 2.9 сая хэрэглэгчдэд 36 тэрбум ам.долларын зээл олгоход зуучилсан бөгөөд баталгаагүй хувийн зээлийн зах зээлд ойролцоогоор 7 хувийг эзэлж байна. Тус платформын шинэлэг арга барил нь боловсрол, ажлын туршлага болон альтернатив өгөгдлүүдийг харгалзан үзэж, эрсдэлийг илүү нарийвчлалтай үнэлэх боломжийг бүрдүүлснээр санхүүгийн хүртээмжийг илүү олон хүнд нээж өгдөг.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/news/top-10-lendtech-platforms>

СУДЛААЧИЙН ИНДЭР

БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ НЬ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хороо, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Сайнбилэг /sainbileg@frc.mn /

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаагаар санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын стандарт, зарчим, улс орнуудын зохицуулалтын туршлага болон тэдгээрийг Монгол Улсад нутагшуулах боломжийг шинжиллээ.

Судалгааны үр дүнд сонгон судалсан улс орнууд нь хэрэглэгчийн эрхийг хамгаалахад чиглэсэн тусгай хуультай, төрийн хяналт, зохицуулалтын байгууллагатай, бие даасан гомдол шийдвэрлэх тогтолцоотой, мөн зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох, санхүүгийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бичил санхүүгийн салбарт тогтвортой, хариуцлагатай орчныг бүрдүүлж байгааг харуулж байна.

Монгол Улсад бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах нэгдсэн хууль эрх зүйн орчин хараахан бүрдээгүй байгаа нь салбарын хөгжлийн нэг сул тал болж байна. Иймээс судалгааны үр дүнд олон улсын сайн туршлагад тулгуурлан авч хэрэгжүүлэх боломжит бодлогын арга хэмжээг санал болгосон.

УДИРТГАЛ

Бичил санхүү нь уламжлалт банкны үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, орлого багатай, эдийн засгийн эмзэг бүлгийн иргэдэд зориулсан санхүүгийн үйлчилгээний хэлбэр юм. Энэ төрлийн үйлчилгээ нь 1976 онд Бангладеш улсад профессор Мухаммад Юнусын санаачилсан Grameen Bank-аас үүсэлтэй бөгөөд ядуурлыг бууруулах, тэр дундаа эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд бэхжүүлэхэд чиглэсэн. Бичил санхүүгийн үйлчилгээ нь барьцаа хөрөнгийн шаардлага бага, уян хатан нөхцөлтэй байдаг нь орлого багатай иргэд, жижиг, дунд бизнес эрхлэгчийг эдийн засгийн идэвхтэй оролцогч болгож, өөрийн жижиг бизнесийг эхлүүлэх, өргөжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх, амьжиргаагаа тогтворжуулах, гэнэтийн эрсдэлээс хамгаалахад чухал дэмжлэг үзүүлдэг.

Сүүлийн жилүүдэд манай улсад бичил санхүүгийн үйлчилгээ өргөжиж, санхүүгийн хүртээмж нэмэгдэж буй хэдий ч хэрэглэгчдийн эрх зөрчигдөх тохиолдол буурахгүй байгаа нь энэ салбар хэрэглэгч төвтэй, оновчтой зохицуулалт, хамгаалалтын тогтолцоо хангалтгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, Монгол Улсын шүүхийн 2022 оны шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ “Банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлтэй холбоотой маргаан 2,681 буюу 89.2 хувиар өссөн” гэж онцолсон байна. Түүнчлэн хэрэглэгчдийн санхүүгийн боловсрол харилцан адилгүй, мэдээллийн тэгш бус байдал байгаа нь эрсдэлийг улам нэмэгдүүлж нэмэгдүүлж буйг тэмдэглэх нь зүйтэй.

Нөгөө талаас, олон улсын туршлагаас харахад бичил санхүүгийн үйлчилгээ нь зөвхөн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна хэрэглэгчийн эрх ашгийг системтэй хамгаалсан, хяналттай, ёс зүйтэй, хариуцлагатай байх нь тогтвортой санхүүгийн салбарын үндэс суурь болдгийг харуулдаг. Судалгаанд хамрагдсан улс оронд хэрэглэгч төвтэй бодлого, ил тод мэдээлэл, зохистой хүүгийн зохицуулалт, бие даасан гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж чадсан нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн сацуу хэрэглэгчдийн эрхийг хамгаалах бодит үр дүнг бий болгож буйг баталж байна.

Монгол Улсад энэхүү чиглэлээр тусгайлсан хууль тогтоомж одоогоор байхгүй, зохицуулалт хэсэгчлэн хэрэгжиж буй тул олон улсын стандарт, туршлагыг судалж, бичил санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох

шаардлага тулгарч байна. Иймд энэхүү судалгааны ажлын зорилго нь бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын стандарт, зарчим, зохицуулалтыг судлан Монгол Улсын эрх зүйн орчны нөхцөл байдалтай харьцуулж, цаашид хэрэгжүүлэх бодлогын чиглэлийг тодорхойлоход оршино.

Судалгааны бүтцийн хүрээнд эхний хэсэгт бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндсэн зарчмууд, дараагийн хэсэгт олон улсын стандартууд болон сонгон судалсан нэр бүхий 5 улсад мөрдөж буй зохицуулалтын арга хэмжээг харьцуулан судлав. Эцэст нь, судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсад бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй боловсронгуй болгох, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх салбарын хариуцлагыг нэмэгдүүлэх, хэрэглэгч төвтэй зохицуулалтыг бий болгох бодлогын санал боловсруулж дэвшүүлээ.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДСЭН ЗАРЧМУУД

Дэлхийн банкнаас 2022 онд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, уг зах зээлд оролцож буй хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор дэлхийн 100 гаруй орныг хамруулсан судалгаа хийсэн.

Уг судалгаанд үндэслэн бичил санхүүгийн салбарт хэрэглэгчийг хамгаалах, хариуцлагатай, тогтвортой үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн олон улсад мөрдөх боломжтой дараах тав үндсэн зарчмыг жишиг болгон тодорхойлсон. Эдгээр зарчим нь хууль, бодлогын түвшинд хэрэгжихээс гадна хэрэглэгчийн бодит эрхийг хангах үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн болно.

1. Мэдээлэл олгох ба ил тод байдал (Disclosure and Transparency);
2. Шударга харьцаа ба бизнесийн ёс зүй (Fair Treatment and Business Conduct);
3. Хариуцлагатай зээл олголт (Responsible Lending);
4. Гомдол хүлээн авах, маргаан шийдвэрлэх тогтолцоо (Complaints Handling, Dispute Resolution, and Recourse);
5. Хувийн мэдээллийн хамгаалалт (Data Protection).

Бичил санхүүгийн үйлчилгээ нь амьжиргааны түвшин доогуур орлого багатай, эмзэг бүлгийн иргэдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чухал хэрэгсэл боловч хэрэглэгчийн эрх зөрчигдөх эрсдэл дагуулдаг. 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаар санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал олон улсын түвшинд онцгой анхаарал татаж эхэлсэн. Иймээс олон улс орон тусгай хууль, зохицуулалт болон байгууллагуудыг бий болгон хэрэглэгчийн эрхийг хамгаалах болсон. Олон улсын хэмжээнд хэрэглэгчдийн эрхийг хамгаалах хэд хэдэн чухал стандарт, зарчим үйлчилж байна. Энэхүү судалгаанд нэр бүхий 5 улсын болон олон улсад мөрдөж буй нэр бүхий 3 стандартыг сонгон судаллаа.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, ЗАРЧМУУД БА УЛС ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Олон улсын стандарт, зарчмууд

CERISE+SPTF Client protection standards

Client Protection Principles (Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зарчмууд) нь анх 2009 онд АНУ-д төвтэй “Center for Financial Inclusion” (CFI) байгууллагын дэргэд хэрэгжсэн “The Smart Campaign” нэртэй олон улсын санаачилгын хүрээнд боловсруулагдсан. Энэхүү зарчим нь төрийн бус иргэний нийгмийн санаачилга бөгөөд хэрэглэгчийг хамгаалах 7 үндсэн зарчмыг тодорхойлсон бичил санхүүгийн байгууллагууд хэрэглэгч төвтэй, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулахад чиглэсэн сайн дурын зарчим байдлаар нэвтэрч эхэлсэн юм.

2020 онд The Smart Campaign үйл ажиллагаагаа зогсоосны дараа энэхүү зарчмуудыг улам боловсронгуй болгож, олон улсын түвшний стандарт болгон хөгжүүлэх ажлыг Францын CERISE болон АНУ-ын Social Performance Task Force (SPTF) гэсэн хоёр иргэний нийгмийн байгууллага хамтран үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Улмаар 2021 онд эдгээр хоёр байгууллага Client Protection Principles-ийг илүү нарийвчилсан шалгуур, хэрэгжилтийн аргачлал бүхий Client Protection Standards болгон шинэчилж баталсан. Энэхүү стандартыг нь 2024 оны байдлаар дэлхийн 100 гаруй орны бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид, зохицуулагч байгууллагууд дагаж мөрдөж байгаа бөгөөд бичил санхүүгийн бодлого, аудит, санхүүжилтийн шалгуурт өргөнөөр ашиглагдаж байна.

CERISE болон SPTF нь “Client Protection Standards”-ын хэрэгжилтийг дэмжих зорилгоор SPI Online үнэлгээний систем,

Client Protection Pathway, үндэсний аудиторуудын сүлжээ, техникийн зөвлөмж, сургалтын багц зэрэг цогц хэрэгслүүдийг санал болгож, байгууллагуудын чадавхыг бэхжүүлэн, бодит хэрэглэгчийн хамгаалалтыг хангах үйл ажиллагаанд хэрэгжүүлж байна. Эдгээр стандартууд нь хууль зүйн заалтууд төдий бус, тухайн байгууллагын дотоод соёл, стратеги, бүтэц, хүний нөөцийн бодлого, менежментийн шийдвэр зэрэгт нэвт шингэсэн байхыг шаарддагаараа онцлог юм.

Энэ стандарт нь дараах 8 дэд хэсгээс бүрдэнэ:

1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний зохистой байдал;
2. Хариуцлагатай зээл олголт;
3. Ил тод, ойлгомжтой мэдээлэл;
4. Зардлын тогтолцоо;
5. Ёс зүйтэй харилцаа, хүний эрхийн хүндэтгэл;
6. Хувийн мэдээллийн хамгаалалт;
7. Гомдол, маргаан шийдвэрлэх тогтолцоо;
8. Удирдлагын оролцоо ба хяналт;

G20 High-Level Principles on Financial Consumer Protection (2011)

G20-ийн орнууд болон Олон улсын санхүүгийн байгууллагууд (OECD, World Bank гэх мэт) хамтран 2011 онд олон улсын санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого, зохицуулалтыг хөгжүүлэх “High-Level Principles on Financial Consumer Protection”-г баталсан. Энэхүү зарчмууд нь хувийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид болон зохицуулагч байгууллагуудын мөрдөх ёстой суурь зарчмуудыг тодорхойлж, G20-ийн 20 орон болон OECD-ийн 38 гишүүн оронд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд дэлхий даяар хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого боловсруулахад жишиг загвар болон үндсэн суурь болгон ашиглагдаж байна.

Уг баримт бичиг нь дараах 10 үндсэн зарчимд тулгуурладаг:

1. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тодорхой эрх зүйн орчин байх;
2. Үйлчилгээ үзүүлэгч болон зохицуулагч байгууллагын харилцан уялдааг хангах;
3. Хэрэглэгчдэд шийдвэр гаргахад шаардлагатай ойлгомжтой мэдээлэл өгөх;
4. Хэрэглэгчдийг санхүүгийн боловсролоор хангаж, хариуцлагатай шийдвэр гаргахад дэмжих;
5. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид шударга ёс зүйтэй хариуцлагатай бизнесийн соёлыг баримталж ажиллах;

6. Хэрэглэгчийн хэрэгцээнд тохирсон, илүү эрсдэлгүй сонголтыг дэмжих;
7. Хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх хүртээмжтэй, үр дүнтэй системтэй байх;
8. Хэрэглэгчийн өгөгдөл, хувийн мэдээллийг нууцлах;
9. Ядуурлыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
10. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

IFC-Good Practices for Financial Consumer Protection

Олон улсын санхүүгийн корпорац (IFC) нь 2010 онд CGAP (Consultative Group to Assist the Poor)-тай хамтран “Good Practices for Financial Consumer Protection” нэртэй удирдамжийг боловсруулсан ба энэ нь хөгжиж буй орнуудын санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлогыг боловсронгуй болгоход чиглэсэн. Энэхүү удирдамж нь 2017 онд шинэчлэгдэн гарсан бөгөөд илүү нарийвчилж, хэрэглээнд суурилсан. Одоогийн байдлаар 100 гаруй улс орон энэхүү баримт бичгийн зарчмуудад үндэслэн хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого, зохицуулалтдаа тусган хэрэгжүүлж байна. Уг удирдамж нь дараах арван чиглэлээр хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог хөгжүүлэхэд чиглэдэг:

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид үйлчлүүлэгчдэд ойлгомжтой, бүрэн, цаг тухайд нь мэдээлэл хүргэх үүрэгтэй. Мэдээлэл нь бүтээгдэхүүний нөхцөл, шимтгэл, хүү, эрсдэл зэрэг чухал талуудыг хамарсан байна.

Хэрэглэгчдийг хуурч мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, шударга бус гэрээ байгуулах үйлдлийг хориглох.

Төрийн болон хараат бус зохицуулагч байгууллагууд нь хяналт тавих, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох бүрэн эрхтэй байна.

Хэрэглэгч гомдол гаргах боломжтой, хараат бус, хүртээмжтэй байдлыг бий болгох.

Хэрэглэгч санхүүгийн бүтээгдэхүүнийг зөв ойлгож, эрсдэлийг ухамсарлан шийдвэр гаргах чадвартай байх ёстой.

Үйлчилгээ үзүүлэгчид хоорондын шударга өрсөлдөөнийг бий болгож, хэрэглэгчдэд олон сонголт олгох.

Хэрэглэгчийн мөнгө, хувийн мэдээллийг хууль бус ашиглалт, залилангаас хамгаалах системтэй байх.

Хэрэглэгчийн мэдээлэл зөвшөөрөлгүйгээр ашиглагдахгүй байх, аюулгүй хадгалагдах шаардлагатай.

Итгэлцлийн санд төвлөрүүлсэн хөрөнгийг тусгайлсан хамгаалалтаар тусгаарлах.

Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчдэд төвтэй, нийгмийн хариуцлагатай, харилцан итгэлцэл дээр суурилсан соёл төлөвшүүлэх.

Дээрх стандарт болон зарчмууд нь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зорилготой хэдий ч хандлага, хэрэгжүүлэх түвшин, хамрах хүрээ, бодлого боловсруулагчдын оролцоо хэрэглээний бүтэц зэргээрээ ялгаатай.

Улс орнуудын зохицуулалт

Уганда Улс

Уганда Улс бичил санхүүгийн байгууллагыг төрийн зохицуулалтад хамруулах зорилгоор 2016 онд “Tier 4 Microfinance Institutions and Money Lenders Act”-ийг баталсан. Уг актаар өмнө нь ямар нэг тусгай зөвшөөрөл, хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан бичил санхүүгийн байгууллагуудыг албан ёсоор бүртгэж, хяналт тавих эрхийг Uganda Microfinance Regulatory Authority (UMRA) нэртэй төрийн байгууллагад олгосон. Энэхүү зохицуулалт нь банк, санхүүгийн өндөр төвшний шалгуураас илүү зөөлөн боловч, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндсэн зарчим буюу ил тод байдал, хүүгийн дээд хязгаар тогтоох, гомдол шийдвэрлэх тогтолцоог нэвтрүүлэх замаар илүү хариуцлагатай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид төрийн хяналт, зохицуулалтын дор ажиллаж хэрэглэгчийн эрхийн хамгаалалд бодитой ахиц авчирсан чухал өөрчлөлт юм.

Уг хуульд хэрэглэгчийн эрхийг хамгаалах дараах гол зохицуулалтууд тусгагдсан:

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчидтэй шударгаар харьцаж, хуурч мэхлэх, төөрөгдүүлэх, эсвэл ялгаварлан гадуурхах аливаа үйлдэл хийхийг хориглох.
- Хэрэглэгчийн тухай аливаа мэдээллийг зөвхөн хэрэглэгчийн зөвшөөрлөөр, эсвэл хуулийн шаардлагаар л гуравдагч этгээдэд өгөх.
- Бүтээгдэхүүний үнэ, хүү, шимтгэл, түүнчлэн нэмэлт зардлыг харилцагчид “key facts document /санхүүгийн бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үндсэн шинж чанаруудыг товч, тодорхой байдлаар харуулсан баримт бичиг/”-оор дамжуулан ойлгомжтой, бичгээр мэдээлэх.
- Зээлийн өмнө хэрэглэгчийн орлого, өр төлбөр, амьжиргааны зардлыг бодитоор үнэлж, хэт өрийн

дарамтад орохоос сэргийлэх.

- Бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн гомдлыг шударгаар, ил тод, түргэн шуурхай шийдвэрлэх журмыг мөрдөх үүрэгтэй бөгөөд гомдлыг 2 долоо хоногийн дотор шийдвэрлэж, гомдлын талаарх мэдээллийг өөрийн бүх харилцааны сувгаар хэрэглэгчдэд ил тод хүргэх ёстой ба хэрэглэгч UMRA-д гомдол гаргасан тохиолдолд дарамт шахалт үзүүлэхийг хатуу хориглох ба жил бүр UMRA-д тайлан хүргүүлэх.

Уганда Улс санхүүгийн боловсролыг дэмжихэд төр, төрийн бус байгууллагууд болон санхүүгийн зохицуулагч байгууллагууд хоорондоо нягт хамтран ажиллаж байна. Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах, мөн санхүүгийн боловсролыг сайжруулах удирдамж, стандартыг боловсруулж, санхүүгийн байгууллагуудад мөрдүүлэх үүрэгтэй. Uganda Bankers Association нь олон нийтийн сувгаар дамжуулан орон нутгийн иргэдэд зориулсан сургалт, мэдээлэл түгээх ажлыг идэвхтэй зохион байгуулдаг. Харин бичил санхүүгийн зохицуулагч UMRA нь PostBank-тай хамтран хадгаламжийн бүлгүүдийг дижитал хэлбэрт шилжүүлэх төсөл хэрэгжүүлж, хэрэглэгчдийн санхүүгийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч байна. Мөн Holt International зэрэг төрийн бус байгууллагууд хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд зориулсан санхүүгийн боловсролын сургалт, хадгаламж үүсгэх, бизнес эрхлэх чадвар олгох сургалтыг явуулж байна. Уганда улс санхүүгийн боловсролыг өргөн хүрээнд дэмжиж, иргэдийн санхүүгийн чадварыг сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Бангладеш Улс

Бангладеш Улсад бичил санхүүгийн байгууллагуудыг 2006 оноос хойш Microcredit Regulatory Authority (MRA) нэртэй бие даасан зохицуулагч байгууллага хариуцан ажиллаж байна. MRA нь бичил зээлийн үйлчилгээ эрхлэгчдэд зөвшөөрөл олгох, хяналт тавих болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах бодлого, журам хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь “NGO-MFI Governance Guidelines” болон “Code of Conduct” зэрэг зохицуулалтыг мөрдүүлж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах олон зарчмыг нэвтрүүлсэн бөгөөд үүнд зээлийн нөхцөл, мэдээллийн ил тод байдал, хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг сахих зэрэг чухал заалтууд багтдаг. Ийнхүү Бангладешийн зохицуулагч байгууллага бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааг хянаж, хэрэглэгчдийг хамгаалах тогтолцоог тогтмол сайжруулж байна.

Зохицуулалтын баримт бичигт хэрэглэгчийн эрхийг хамгаалах дараах гол зохицуулалтууд тусгагдсан:

- Зээл олгохдоо хэрэглэгчийн санхүүгийн чадавхыг үнэлж, зээлдэгчийн өр төлбөрийн чадварыг бодитоор дүгнэх үүрэгтэй бөгөөд дунд болон богино хугацааны зээлийн хүү, шимтгэл, бусад нэмэлт төлбөрийг зохицуулсан дээд хязгаар тогтоосноор хэрэглэгчийг хэт их санхүүгийн дарамтаас хамгаалдаг.
- Хэрэглэгчийн хувийн болон санхүүгийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулах, ил болгохыг хориглоно. Энэ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чухал нөхцөл бөгөөд зөрчигдсэн тохиолдолд зохих арга хэмжээ авна.
- Бичил санхүүгийн байгууллагууд хэрэглэгчийн гомдлыг шуурхай хүлээн авч, шударгаар шийдвэрлэхэд зориулсан бичгээр тогтоосон гомдлын менежментийн процесс бий болгох шаардлагатай. Мөн хэрэглэгч гомдлоо шийдвэрлүүлж чадахгүй тохиолдолд зохицуулагч байгууллагад хандах боломжтой.
- Бичил санхүүгийн байгууллагууд өөрийн үйлчилгээний нөхцөл, зээлийн хүү, шимтгэл, бусад төлбөрийн талаарх мэдээллийг хэрэглэгчид ойлгомжтой, тодорхой байдлаар бичгээр болон бусад тохиромжтой хэлбэрээр хүргэх үүрэгтэй. Энэ нь хэрэглэгч зөв мэдээлэл дээр суурилсан шийдвэр гаргахад тусална.

Бангладеш Улсад санхүүгийн боловсрол олгох үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран явуулдаг. Тэдгээр нь бичиг үсэг тайлагдаагүй, мэдээлэл хязгаарлагдмал хүмүүст хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар сургалт зохион байгуулдаг. Тухайлбал, зурагт ном, зурагт хуудас, богино хэмжээний видео материалыг ашиглан санхүүгийн үндсэн ойлголт, хадгаламжийн ач холбогдол, зээлийн хэрэглээ зэрэг сэдвүүдийг тайлбарладаг. Sanasa Development Bank, BRAC Education Program зэрэг байгууллагууд энэхүү боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийн санхүүгийн мэдлэг, чадварыг сайжруулдаг. Ингэснээр иргэд санхүүгийн шийдвэрээ илүү ухаалгаар гаргаж, санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой.

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улсад бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндсэн зохицуулалтыг хэд хэдэн хууль тогтоомжоор хэрэгжүүлдэг. Тухайлбал, “Хэрэглэгчийн эрхийг

хамгаалах тухай хууль” (1992) нь бүх төрлийн хэрэглэгчдийг, түүний дотор бичил санхүүгийн хэрэглэгчдийг шударга, ил тод үйлчилгээ авах эрхээр хангах үндсэн үндэс суурийг тавьсан байдаг. Уг хуульд хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, худал мэдээллээс хамгаалах, бараа үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, гомдол гаргах болон шүүхэд хандах эрх зэргийг нарийвчлан тусгасан.

Мөн “Бичил санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль” (2010) нь бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг тодорхой зохицуулж, хэрэглэгчийн төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн нөхцөл, хүү, нэмэлт төлбөрийг тодорхой, ойлгомжтой байдлаар харуулахыг шаарддаг. Энэ хууль нь тодорхой шалгуур хангасан бичил санхүүгийн байгууллагуудад үйл ажиллагаа явуулах эрх олгох, зөрчил гаргасан тохиолдолд хяналт шалгалт, шийтгэл ногдуулах зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн хэрэглэгчийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглох, хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэхэд чиглэсэн механизмыг хөгжүүлэх заалтуудыг тусгасан байдаг. Эдгээр хууль нь Оросын бичил санхүүгийн хэрэглэгчдийг хэт өндөр хүү, давтан зээл олголт зэрэг эрсдэлээс хамгаалах, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг (Federal Law No. 2300–1, 1992; Federal Law No. 151–FZ, 2010).

Тус хуульд хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр дараах гол зохицуулалтууд тусгагдсан:

- Хэрэглэгч нь аюулгүй, чанартай бараа, үйлчилгээ авах, өөрийн хүссэн бараа үйлчилгээний сонголт хийх, мэдээлэл авах бүрэн эрхтэй. Бараа, үйлчилгээ нь хууль тогтоомж, стандарт, техникийн шаардлагыг хангаж байх.
- Бараа, үйлчилгээний үнэ, чанар, гарал үүсэл, хэрэглээний заавар зэрэг мэдээллийг хэрэглэгчдэд ойлгомжтой, тодорхой, үнэн зөвөөр өгөхийг заадаг. Худалдан авалт хийхэд сөрөг нөлөөтэй худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөхийг хориглоно.
- Хэрэглэгчийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглодог. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэг үйлчилгээ үзүүлэгчид ногдоно.
- Хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, шударга, хурдан шуурхай шийдвэрлэх үүрэгтэй. Хэрвээ үйлчилгээ үзүүлэгч шийдвэрлэхгүй бол хэрэглэгч хуулийн дагуу шүүхэд хандах эрхтэй.

- Бараа, үйлчилгээ нь хэрэглэгчийн эрүүл мэнд, амь насанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ёстой. Хэрэв аюулгүй байдлын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүн олдсон бол худалдаалах, ашиглахыг хориглоно.
- Хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцож, хэрэглэгчийн учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр зохицуулсан. Үүнд бүтээгдэхүүний чанар муу, үйлчилгээний алдаа зэрэг багтана.
- Хэрэглэгчийн эрхийг зөрчихүйц гэрээ, нөхцөл байж болохгүй. Гэрээний аль нэг талд давамгайлал тогтоох, хэрэглэгчийн эрхийг хязгаарлах заалтыг хуулиар хориглоно.

Оросын Холбооны Улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн хүрээнд гомдол, маргааныг шийдвэрлэхэд омбудсмен буюу хэрэглэгчийн эрхийг хамгаалах төлөөлөгчид чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэрэглэгч үйлчилгээний чанар, нөхцөлтэй холбоотой асуудалтай тулгарсан үед эхлээд үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж, гомдлоо шийдвэрлүүлэх боломжтой боловч хэрэв шийдэл олдохгүй бол орон нутгийн омбудсмен болон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах албад хандах эрхтэй. Омбудсмен нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, гомдлыг судлан шударгаар шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, маргааныг хурдан шуурхай шийдвэрлэхэд хувь нэмэр оруулдаг. Ийнхүү омбудсменийн оролцоо нь Оросын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуульд заасан эрх зүйн механизмд суурилсан бөгөөд хэрэглэгчдийг хамгаалах үр дүнтэй институцийн нэгэн гол хэсэг юм.

Түүнчлэн, 2011 оноос эхлэн Санхүүгийн боловсролын үндэсний стратегийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд үүний хүрээнд бичил санхүүгийн хэрэглэгчдийг мэдээлэлтэй болгох, санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал, сургалтын гарын авлага, танин мэдэхүйн материалууд, онлайн сургалт, мэдээллийн вэб хуудас ашиглан иргэдэд санхүүгийн боловсрол олгох зэрэг болно. Энэхүү стратеги нь иргэдийн санхүүгийн шийдвэр гаргах чадварыг сайжруулж, эрхээ хамгаалах түвшнийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үр дүнтэй алхам болж байна. Энэ арга хэмжээ нь ОХУ-ын санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон боловсролын байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүн гэж хэлж болно.

Сингапур Улс

Сингапур Улсад бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах гол зохицуулалт нь “Moneylenders Act” (2008 онд батлагдсан бөгөөд 2018 онд шинэчлэгдсэн) –д суурилдаг. Энэхүү акт нь зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэж, тэдний үйл ажиллагааг хянах, зохицуулах үүрэгтэй бөгөөд зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, шударга бус практик үйлдлээс хамгаалах зэрэг зохицуулалтыг бий болгодог.

Сингапурын Хууль зүйн яамны харьяа Зээлийн Зохицуулах Алба (Registry of Moneylenders) нь уг актыг хэрэгжүүлэх, зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх, үйл ажиллагааг нь хянах, хэрэглэгчдийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй байгууллага юм. Тус алба нь хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор зээлийн нөхцөл, хүү, төлбөрийг ил тод, ойлгомжтой мэдээлэх, хэт өндөр хүү болон давтан зээл олгохгүй байх, хэрэглэгчийн мэдээллийг нууцлах зэрэг чухал стандартыг мөрдүүлдэг. Ийнхүү Сингапурын зохицуулалтын тогтолцоо нь хэрэглэгчдийг шударга бус зээлээс хамгаалах, санхүүгийн зах зээлийг тогтвортой байлгах үндсэн суурь болж байна.

Тус баримт бичигт санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр дараах гол шаардлагуудыг мөрдүүлж, хэрэглэгчийг хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Зээл олгохоос өмнө зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлж, тэдний төлбөрийн чадварт тохирсон зээл олгох.
- Зээлийн жилийн хүүг тодорхой хязгаарлах бөгөөд энэ нь 4% ба түүнээс дээш хэтрэхийг хориглоно. Мөн бусад нэмэлт төлбөрүүдэд тодорхой хязгаарлалт тавьж, хэрэглэгчдийг хэт өндөр зардлаас хамгаална.
- Зээлдэгчдэд зээлийн нөхцөл, хүүгийн түвшин, төлбөрийн хугацаа, нэмэлт төлбөрүүдийг тодорхой, ойлгомжтой хэлбэрээр зааж өгөх шаардлагатай. Үүнд бичгээр гэрээ байгуулах болон бүх чухал мэдээллийг баримтжуулах багтана.
- Хэрэглэгчийн хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.
- Зээлийн үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн гомдлыг хүлээн авч, шударгаар шийдвэрлэх. Мөн хэрэглэгчид Зээлийн Зохицуулах Алба (Registry of Moneylenders)–нд хандаж гомдол гаргана.
- Хуулийг зөрчсөн зээлдүүлэгчид өндөр торгууль, эрхийг түдгэлзүүлэх болон бусад хууль эрх зүйн арга хэмжээ авах боломжтой. Энэ нь хууль сахиулахад өндөр үр дүнтэй хяналт, сахилгын механизм болж ажилладаг.

Санхүүгийн боловсролыг сайжруулах зорилгоор Засгийн газрын санхүүгийн зохицуулах байгууллага болох Monetary Authority of Singapore (MAS) нь иргэдэд зориулсан санхүүгийн боловсролын хөтөлбөр, сургалт, цахим контент, аппликейшн зэрэг олон хэрэгслийг боловсруулан түгээдэг. Үүнд санхүүгийн суурь мэдлэг, хадгаламж, хөрөнгө оруулалт, зээлийн зохистой хэрэглээ, эрсдэл менежмент зэрэг сэдвүүд багтдаг. Мөн их сургуулиуд, төрийн бус байгууллагуудтай хамтран залуучууд болон өрхийн түвшинд зориулсан сургалт, сургалтын материал гаргах, олон нийтийн мэдээлэл түгээх үйл ажиллагааг идэвхтэй явуулж байна. Ийм арга хэмжээнүүд нь иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн шийдвэр гаргах чадварыг сайжруулахад чиглэсэн бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Монгол Улс

Монгол Улсад банк, санхүүгийн үйлчилгээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах харилцааг “Иргэний хууль”, “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль”, “Зар сурталчилгааны тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль”, “Банкны тухай хууль”-иудаар тус тус зохицуулж байна. Эдгээр хууль тогтоомжид хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар ерөнхий заалтууд байдаг. Жишээлбэл:

- “Иргэний хууль”-ийн 24 дүгээр бүлэгт гэрээний хугацаа, хүү, хүчин төгөлдөр байдлын талаар заасан тусгасан ч ямар тохиолдолд гэрээг хүчингүй болгох нөхцөлийг тодорхой тусгаагүй болно.
- “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль” нь бараа, бүтээгдэхүүн /цаашид "бараа" гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог боловч бичил санхүүгийн онцлог, эрсдэлд тохирсон тусгай зохицуулалтыг тусгаагүй.

Ийнхүү өнөөгийн байдлаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой тусгайлсан хууль, цогц эрх зүйн зохицуулалт батлагдаагүй ч, үүнд анхаарал хандуулсан байна. Тухайлбал, 2019 онд Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир, С.Батболд нар хамтран “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулан, УИХ-ын даргад өргөн барьсан. Энэхүү хуулийн төсөл нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн хоорондын мэдээллийн тэгш бус байдал, шударга бус гэрээ, гомдол, маргааны шийдвэрлэлтийн механизм зэрэг олон

чухал асуудлыг зохицуулах зорилготой юм.

Мөн Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны А-106/298 дугаар хамтарсан тушаалаар “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ыг баталсан. Уг аргачлалыг банк, эрх бүхий хуулийн этгээд мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаанд мөрдөж байна. Мөн олон улсын байгууллагуудын зүгээс санхүүгийн салбарын зохицуулалтад үнэлгээ хийж, сайжруулах зөвлөмж өгсөн байдаг. Жишээлбэл, 2012 оны Дэлхийн банкнаас гаргасан “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношилгоо дүгнэлт”-эд Монгол Улсад бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах зохицуулалт санхүүгийн тухайн салбарын хууль, дүрэм журмаар хэсэгчлэн зохицуулагддаг бөгөөд тус зохицуулалт нь уялдаа холбоо сул байгааг дурджээ. Түүнчлэн Дэлхийн банкнаас хүүлэлтийн шинжтэй зээлийн бодит үйл ажиллагаа болон зээл авахад шаардаж буй хэт их шаардлагууд нь хүн амын ялангуяа эмзэг хэсгийн сегментэд сөрөг нөлөөтэй байгааг судлаад энэ чиглэлээр эрх зүйн орчны болон бусад өөрчлөлт хийхийг зөвлөсөн. Дэлхийн банкнаас гаргасан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн 5 зарчимд тулгуурлан Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлыг тодруулбал:

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын санхүүгийн салбарын мэргэжлийн холбоодтой нягт хамтран ажилладаг. Тус хорооноос бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд хүүгийн мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх үүрэг өгсөн бөгөөд энэхүү мэдээллийг тогтмол цуглуулж, салбарын нэгтгэлээр дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Энэ нь хэрэглэгчдэд харьцуулалт хийх, хэт өндөр хүүтэй үйлчилгээ авах эрсдэлээс сэргийлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломжийг олгож байна.

Хэрэглэгчийн өрийн дарамтаас хамгаалах зорилгоор хэрэглээний зээл олгох өр/орлогын харьцааг 60:40-оор тогтоосон. Ингэснээр хэрэглэгчийн төлбөрийн чадварт үндэслэн шийдвэр гаргах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдсэн.

Монгол Улсад санхүүгийн салбарын хэрэглэгчдээс гаргасан өргөдөл, гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулиар шийдвэрлэдэг.

Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн хувийн мэдээлэл, нууцлалтай холбоотой харилцааг “Хувь хүний нууцын тухай хууль” болон “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-аар тус тус зохицуулдаг. “Хувь хүний нууцын тухай хууль” нь иргэний хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулах, ашиглах, түгээхээс хамгаалах үндсэн зохицуулалтыг агуулдаг бол “Кибер аюулгүй байдлын тухай хууль” нь цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх, кибер халдлагад өртөхөөс хамгаалах чиглэлээр тусгай зохицуулалт хийдэг.

Санхүүгийн зохицуулах хорооны Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг сарын 4.5 хувь байхаар тогтоосон. Тус зээлийн хүүгийн дээд хэмжээ, зээл, барьцаа, батлан даалтын гэрээний ерөнхий загвар, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон улсын стандарт, зарчим, зохицуулалтыг Монгол Улсын нөхцөл байдалтай харьцуулан судаллаа. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал нь зөвхөн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдэхээс гадна санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал, хүртээмж, иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймд дэлхийн улс орнууд энэ чиглэлд бодлого, зохицуулалт, институцийн чадавхаа тасралтгүй сайжруулж, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг бодитойгоор хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлд цогц бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

2022 онд Дэлхийн Банкнаас гаргасан удирдамжид санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд дараах таван үндсэн зарчмыг дагаж мөрдөх шаардлагатайг онцолсон. Үүнд хэрэглэгчдэд ойлгомжтой, иж бүрэн мэдээлэл өгөх болон ил тод байдлыг хангах; шударга харьцаа, бизнесийн ёс зүйг баримтлах; зээлийг хариуцлагатайгаар олгох; гомдол, маргааныг шударгаар, үр дүнтэй шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх; хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах зохистой зохицуулалтыг хэрэгжүүлэх зэрэг багтдаг. Мөн олон улс оронд хэрэглэгчийн эрхийг хамгаалах хэд хэдэн зарчим, стандартууд хэрэгждэг. Үүнд CERISE+SPTF, G20, IFC зэрэг байгууллагуудын баталсан олон улсын хүрээнд хэрэгжих жишиг хэм хэмжээнүүд багтдаг. Эдгээр стандарт нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах нь зөвхөн хууль эрх зүйн орчноор хязгаарлагдахгүй, харин байгууллагын дотоод бодлого, стратеги, хүний нөөцийн чадавх, засаглалыг сайжруулах шаардлагатайг онцолдог бөгөөд эдгээр нь олон улс орон тухайлбал Уганда, Бангладеш, Орос, Сингапур зэрэг улс орнуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх үндсэн суурь болсон байна.

Тухайлбал, Уганда Улс бичил санхүүгийн байгууллагуудыг ангилан зохицуулах замаар “Tier 4 MFIs Act” (2016)-ийг баталж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгай заалтуудыг тусгасан. Бангладеш улсын хувьд бичил санхүүгийн хэрэглэгчдийг хамгаалах суурь зохицуулалт нь “NGO-MFI Governance Guidelines” болон “Code of Conduct” бөгөөд хэрэглэгчийн эрхийг хамгаалах хамгийн үр дүнтэй арга бол санхүүгийн боловсрол гэж үздэг бөгөөд Sanasa Development Bank, BRAC Education Program зэрэг байгууллагууд орон нутгийн иргэд, ялангуяа эмэгтэйчүүдийг хамарсан санхүүгийн сургалтын хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Оросын Холбооны Улсад бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахад Төв банк гол үүрэг гүйцэтгэхээс гадна, Санхүүгийн Омбудсменийн тогтолцоог хэрэгжүүлдгээрээ онцлогтой. Энэ нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой иргэдийн гомдлыг хараат бус, шуурхай, шударгаар шийдвэрлэх механизмыг бүрдүүлж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээ бөгөөд банк бус санхүүгийн байгууллага, бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, даатгал болон хөрөнгийн зах зээлтэй холбоотой маргаанд оролцож буй хэрэглэгчдэд үнэ төлбөргүй зуучлалын үйлчилгээ үзүүлдэг. Олон улсын туршлага болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг гурван түвшинд ангилан дэвшүүлж байна:

1. Зохицуулалтын түвшинд:

- “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийг батлуулах;
- Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжид бичил санхүүгийн хэрэглэгчийг тусгай бүлгээр тодорхойлж, эрх зүйн баталгааг нарийвчлан тусгах;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд хараат бус “Санхүүгийн хэрэглэгчийн омбудсмен” бүтэц байгуулж, хэрэглэгч

төвтэй хяналтын тогтолцоог бүрдүүлэх (ОХУ–ын жишгээр хэрэглэгчийн эрхийг шуурхай, шударгаар хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх);

- Хэрэглэгчийн гомдол, маргааны шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод болгох;
- Эмзэг бүлгийн иргэдэд зориулсан “тусгай үйлчилгээний стандарт” болон аргачлал боловсруулах (жишээ нь: гэрээний нөхцөлийг дохионы хэл, дүрслэл, видео хэлбэрээр тайлбарлах);
- Хэрэглэгч гэрээ байгуулахаас өмнө эрх зүйн зөвлөгөө авах боломжийг хуульчлан баталгаажуулах.

2. Бичил санхүүгийн байгууллагуудын түвшинд:

- Хэрэглэгчтэй харилцах ёс зүйн кодыг мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- Санхүүгийн бүтээгдэхүүн бүрийн тайлбар, холбогдох мэдээллийг бичгээр хавсаргах, мөн хэрэглэгчид амаар эрсдэлийг тайлбарлах замаар мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Хэрэглэгчдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө, мэдээллийн хөтөлбөрийг тогтмол зохион байгуулах.

3. Хэрэглэгчийн түвшинд:

- Зээл болон бусад бүтээгдэхүүн авахын өмнө эрсдэлийг ойлгож, гэрээний нөхцөлийг бүрэн унших;
- Эрх нь зөрчигдсөн тохиолдолд хаана, хэрхэн албан ёсоор хандах талаар мэдээлэлтэй байх;
- Өөрийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай харилцахаас өмнө тухайн байгууллагын зөвшөөрөл, бүртгэлийн байдлыг шалгах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- CGAP. (n.d.). Bangladesh Microfinance Regulatory Authority overview. <https://www.cgap.org/>
- Consumer Financial Protection Bureau (CFPB). (n.d.). Consumerfinance.gov. <https://www.consumerfinance.gov>
- CERISE & SPTF. (2022). Client protection standards manual. <https://sptf.info/universal-standards-for-spm>
- Financial Consumer Protection Guidelines for Tier 4 Microfinance Institutions and Money Lenders. (2019). <https://umra.go.ug/wp-content/uploads/2023/04/FINANCIAL-CONSUMER-PROTECTION-GUIDELINES-FINAL-TWO.pdf>
- G20. (2011). High-level principles on financial consumer protection. OECD. <https://www.oecd.org/daf/fin/financial-education/G20-OECD-Principles-Financial-Consumer-Protection.pdf>
- Microcredit Regulatory Authority Act. (2006). Bangladesh Bank. <https://www.bb.org.bd>
- Microcredit Regulatory Authority Act. (2006). Microcredit Regulatory Authority. <https://www.mra.gov.bd>
- Ministry of Law Singapore. (2018). Moneylenders (Amendment) Act & Rules. moneyloans.com.sg; licensedmoneylender.com; bestcredit.sg
- OECD. (2011). G20/OECD high-level principles on financial consumer protection. <https://www.oecd.org/finance/financial-education/G20-OECD-Financial-Consumer-Protection-Principles.pdf>
- Online Credit. (n.d.). Singapore Moneylender Act guide. moneyloans.com.sg; onlinecredit.com.sg; quickcredit.com.sg
- Parliament.mn. (2019, December 2). Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл өргөн барилаа. <https://www.parliament.mn/nn/9795>
- Quick Credit®. (n.d.). Licensed money lender new rules: Consumer protection measures. quickcredit.com.sg
- Registry of Moneylenders, Singapore Ministry of Law. (n.d.). <https://www.mlaw.gov.sg/content/minlaw/en/departments/registry-of-moneylenders.html>
- Singapore Ministry of Law, Registry of Moneylenders. (n.d.). <https://www.mlaw.gov.sg/content/minlaw/en/departments/registry-of-moneylenders.html>
- Tier IV Microfinance Institutions Act. (2016). Uganda Legal Information Institute. <https://ulii.org/akn/ug/act/2016/18/eng>
- World Bank. (2017). Good practices for financial consumer protection. Washington, DC: World Bank. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/28996>
- “О микрофинансовой деятельности и микрофинансовых организациях.” (2010). Федеральный закон №151–ФЗ. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_103927/
- “О потребительском кредите (займе).” (2013). Федеральный закон №353–ФЗ. http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_144005/

МӨНГӨ ХҮҮЛЭЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Хуулиар тогтоосон хэмжээнээс давсан, үндэслэлгүй өндөр хүүтэй мөнгө зээлдүүлэх явдал.



МӨНГӨ ХҮҮЛЭЛТИЙН СХЕМ

Барьцаа хөрөнгө

Зээлийн хэмжээнээс хэт давсан барьцаа хөрөнгө

Зээлдэгч

- Мэдээлэл дутмаг
- Санхүүгийн ойлголт сул

Мөнгө хүүлэгч

- Богино хугацаатай жишээ нь: Өдрийн зээл
- Бага дүнтэй зээл олгох

Зээл

- Богино хугацаатай
- Бага хэмжээтэй
- Хүүгийн хувьд өндөр

Мөнгө хүүлэх нийтлэг аргууд:

- 1 Хэт өндөр/нууцлаг хүү тогтоох – Зээлийн хүүг ердийн хэмжээнээс хэт өндөр тогтоох; хүүгийн мэдээллийг бичгээр өгөхөөс зайлсхийх;
- 2 Нэмэлт нууц шимтгэл, торгууль авах – Зээлийн гэрээнд олон жижиг заалт оруулж нэмэлт төлбөрүүд ногдуулах Жишээ нь: бичиг баримтын шимтгэл, хугацаа хэтрүүлсний өндөр торгууль, заавал даатгал гэх мэт;
- 3 Богино хугацааны өндөр хүүтэй зээл – 7–30 хоногийн богино хугацаатай ч өндөр хүүтэй, хугацаандаа төлж чадахгүй бол нэмэгдсэн торгууль хуримтлагдаж өр өсөх;
- 4 Барьцаагаар дарамтлах – Барьцааг бодит үнээс нь бага үнэлэх, түүнийг буцаан авах нөхцөл тодорхой бус байх, мөн зээлийн хугацаа дуусмагц барьцааг өөртөө ашигтайгаар хураан авах;
- 5 Дарамт, заналхийллийн тактик ашиглах – Зээлээ төл гэж байнга залгах, айлган сүрдүүлэх, бичиг баримт хурааж дарамтлах;
- 6 “Давхар зээл” олгох – Нэг зээлээ төлөхийн тулд дахин зээл авахыг шаардах. Ингэснээр хэрэглэгчид өр нэмэгдэж “өрийн гинж” үүсэх;
- 7 Барьцааг зориуд хураах зорилготой зээл – Зээлийн хугацаа дуусангуут шууд барьцааг хураах нөхцөлтэй. Зээл олгох зорилго нь барьцаа авах шалтаг байх зэрэг хэлбэрүүд хамаарна.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

Мөнгө хүүлэлтээс хэрхэн хамгаалах вэ?



Зээл олгож буй байгууллага, хувь хүн нь албан ёсны тусгай зөвшөөрөлтэй эсэх;



Хүү, шимтгэл, барьцаа, торгуультай холбоотой эрх зүйн зохицуулалтыг мэдэж байх;



Хүү, шимтгэл, торгууль, хугацаа, нөхцөл зээлийн гэрээнд бүрэн тусгагдсан эсэх;



Орлого, зарлагаа бодитой тооцож эргэн төлөх боломжоо тодорхойлох;





Машин, үл хөдлөх хөрөнгө, үнэт эдлэл зэрэг өндөр үнэ бүхий барьцааг алдах эрсдэлээ тооцох.



Өмнөх зээлээ хаахын тулд дахин зээл авахгүй байх, “өрийн гинж”-нд орохоос болгоомжлох;

Та мөнгө хүүлэлтэд өртсөн гэдгээ мэдсэн бол:

- 1 Овог, нэр, оршин суугаа газрын хаяг, буцах цахим шуудангийн хаяг, утасны дугаар, огноо гомдол бичих болсон шалтгаан зэргийг бичиж гарын үсгээ зурж баталгаажуулна. 
- 2 Гомдолд дурдсан шалтгаанд холбогдох, нотлох баримтыг бүрдүүлж хавсаргана.
 - Гомдол, холбогдох баримт бичгээ доорх байгууллагуудын аль нэгэнд хүргүүлнэ.
 - Гомдолд холбогдох, нотлох баримтыг бүрдүүлж хавсаргана. 
 - Овог, нэр, оршин суугаа газрын хаяг, буцах цахим шуудангийн хаяг, утасны дугаар, огноо зэргийг бичиж гарын үсгээр баталгаажуулна.
- 3 Гомдол, холбогдох баримт бичгээ хүргүүлэх:

Монополын эсрэг газар	Санхүүгийн зохицуулах хороо	Цагдаагийн байгууллага
Хэрэглэгчийн эрх зөрчигдсөн /өндөр хүү, нууц шимтгэл, шударга бус зээлийн нөхцөл, санхүүгийн үйлчилгээний гэрээний нөхцөл/	Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээд /ББСБ, ХЗХ, МЗҮАЭ/ хууль бус үйлдэл, өндөр хүүтэй зээл, санхүүгийн үйлчилгээний гэрээний нөхцөл зөрчигдсөн, эрхэнд халдсан гэх мэт	Хууль бус барьцаа авах, хөрөнгө булаах оролдлого, сүрдүүлэг, хүч хэрэглэсэн гэх мэт гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл харьяа цагдаагийн байгууллагад хандах
Холбоо барих утас: 51263225, Цахим хаяг: contact@ama.gov.mn Байршил: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр	Холбоо барих утас: 51-264444 , 51-261275 (Өргөдөл, гомдол хүлээн авах), Цахим хаяг: info@frc.mn Байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр	102



Хууль, гэрээнд заасан эрх ашиг зөрчигдсөн болон торгуулийг хүчингүй болгуулах, хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг нөхцөлд харьяаллын дагуу шүүхэд хандана.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ИЕНЭЭР БАТАЛГААЖСАН СТЕЙБЛКОЙН ГАРГАГЧ ЯПОНЫ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОО НЭМЭГДЭХИЙГ ТААМАГЛАВ



ТОКИО, 11-р сарын 12 – Ройтерс

Японы анхны иенээр баталгаажсан тогтвортой коин гаргагч JPYC компани Засгийн газрын бондын (JGB) томоохон худалдан авагч болж, Төв банкны мөнгөний бодлогод нөлөөлөх боломжтой гэж тус компанийн гүйцэтгэх захирал Норитака Окабе мэдэгдлээ. JPYC компани 2024 оны 10 дугаар сарын 27-нд иентэй холбосон JPYC тогтвортой коиноо гаргасан бөгөөд 11 дүгээр сарын 12-ны байдлаар 143 сая иений хэмжээтэй арилжаа хийж, 4,707 данс эзэмшигчтэй болжээ. Компанийн зорилго нь гурван жилийн дотор 10 их наяд иений эргэлтэд хүрэх юм. JPYC-ийн нөөцийн 80 хувийг Японы Засгийн газрын бонд, 20 хувийг банкны хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд энэ нь Төв банк (BOJ)-ны бонд худалдан авалтыг бууруулж буй нөхцөлд шинэ эрэлт бий болгож магадгүй гэж үзэж байна. Окабе хэлэхдээ, “Тогтвортой коины зах зээлд доллар давамгайлж байгаа нь Японы компаниудад эрсдэлтэй. Япон Улс иений байр суурийг дэлхийн зах зээлд баталгаажуулах ёстой” гэжээ.

BOJ одоогоор JGB зах зээлийн 50 орчим хувийг эзэмшдэг ч сүүлийн жилүүдэд худалдан авалтаа багасгаж байгаа. Үүний улмаас JPYC зэрэг тогтвортой коин гаргагчид бондын шинэ гол худалдан авагч болох магадлалтай гэж шинжээчид үзэж байна. Мөн Японы гурван том банк Төв

банкны дэмжлэгтэйгээр иентэй холбосон тогтвортой коины хамтарсан туршилтыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь дижитал санхүүгийн экосистемийн өргөжилтэд чухал алхам болно гэж ажиглагчид онцолжээ. Гэвч зохицуулагчид тогтвортой коин нь банкны системээс гадуурх хөрөнгийн хөдөлгөөнийг нэмэгдүүлж, дэлхийн төлбөрийн урсгалд арилжааны банкуудын үүргийг бууруулж болзошгүй талаар анхааруулж байна.

Эх сурвалж: www.reuters.com

ТРАМП 50 ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН САНААГ ДЭВШҮҮЛЛЭЭ

АНУ-д анх удаа орон сууц худалдан авч буй иргэдийн дийлэнх нь 30 жилийн хугацаатай орон сууцны зээл авдаг.



Харин Трампын засаг захиргаанаас дэвшүүлсэн шинэ саналын дагуу тэд удахгүй илүү урт хугацаатай зээлийн сонголттой болох боломжтой болж байна.

Ерөнхийлөгч Дональд Трамп энэ долоо хоногт орон сууцны үнийн өсөлт, хүртээмжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 50 жилийн хугацаатай ипотекийн зээл нэвтрүүлэх санааг танилцууллаа. Холбооны Орон сууцны санхүүжилтийн агентлагийн захирал Билл Пулте уг саналыг “тоглоомын дүрмийг бүхэлд нь өөрчилсөн алхам” хэмээн тодорхойлсон байна.

Засаг захиргааны тайлбарласнаар 50 жилийн зээл нь сар бүрийн төлбөрийг бууруулж, орон сууцны зах зээлээс шахагдаж буй олон америкчуудад боломж олгоно гэж үзэж

байна.

Гэвч орон сууцны салбарын зарим шинжээчид уг санаа эсрэг үр дүнд хүрч болзошгүйг анхааруулжээ. Тэдний үзэж буйгаар зээлийн хугацааг сунгаснаар нийт зардал нэмэгдэж, илүү их хүү төлөхөөс гадна орон сууцны үнийг өсгөх эрсдэлтэй.

Өмнөд Калифорнийн их сургуулийн Маршаллын Бизнесийн сургуулийн профессор Ричард Грин “Энэ бол тийм ч оновчтой санаа биш” хэмээн хэлжээ. Түүний хэлснээр “сар бүрийн төлбөр бага байх нь зөв боловч, хүмүүс зээлээ бүрэн төлж дуусгах хүртэл маш удаан хугацаа шаардагдах тул эрсдэл нэмэгдэнэ” гэжээ.

Эх сурвалж: www.cnn.com

ЯПОНЫ ЭДИЙН ЗАСАГ ЗУРГААН УЛИРЛЫН ДАРАА АНХ УДАА АГШИВ



ТОКИО, 11-р сарын 17 (Reuters) – АНУ-ын тарифын нөлөөгөөр экспорт буурсны улмаас Японы эдийн засаг энэ оны 7–9-р сард 1.8% агшиж, зургаан улирлын дараах анхны уналтад орсныг Засгийн газрын мэдээлэл харууллаа.

Автомашин үйлдвэрлэгчдийн экспорт тариф хэрэгжихээс өмнө огцом өссөн ч дараа нь эрс буурсан нь эдийн засгийн уналтын гол хүчин зүйл байв. Мэргэжилтнүүдийн хэлснээр, орон сууцны хөрөнгө оруулалт нь шинэ зохицуулалтын улмаас буурч, экспорт мөн суларсан хэдий ч эдийн засаг дараагийн 1–2 жилд аажмаар сэргэх төлөвтэй байна.

Эдийн засагчдын ихэнх нь энэ уналтыг Төв банк (BOJ)-ны бодлогын хүүгийн шийдвэрт томоохон нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа бол Ерөнхий сайд Такайчигийн зөвлөх эдийн засагч “12 дугаар сард хүү нэмэгдүүлэх нь буруу алхам болно” хэмээн онцолжээ.

Эх сурвалж: www.reuters.com


WORLD FINANCE

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 11 дүгээр сарын 23-н өдөр


S&P 500 / ^GSPC/

6,6002.99 +64.23 (+0.98%)




Nikkei 225 / ^N225/

48,625.88 -1,198.02 (-2.40%)




FTSE 100 / ^FTSE/

9,539.71 +12.06 (+0.13%)



NASDAQ Composite (^IXIC)

22,273.08 +195.08 (+0.88%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

ШУДАРГА ӨС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/

